



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл  
2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Баасан гараг

|                                          |              |
|------------------------------------------|--------------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>   | <b>1</b>     |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | <b>2-9</b>   |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | <b>10-38</b> |

---

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |       |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| 1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/                                                                                                                                          | 10-11 |
| 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/                                                                                                                                                                                                                                                                                                             | 11-12 |
| 3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/                                                                                                                                         | 12-13 |
| 4.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/ | 13-16 |
| 5.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /эцсийн хэлэлцүүлэг/                                                                                                                                                                                                                                                               | 16-27 |
| 6.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл                                                                                                                                                                                                                                                   | 27-28 |
| 7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/                                                                                                                                                                                                                                                                        | 29-38 |

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 07 дугаар сарын 04-ний өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Ганбаатар.

***Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга

Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Макро, эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 09 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Батжаргал, Б.Мөнхсоёл, Б.Уянга, Б.Түвшин, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл, Ж.Батжаргал нарын гаргасан, тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын

төсөл хэрэгжиж байгаагаас өмнө үр өгөөжийн дийлэнхийг үлдээх гэснийг хасах гэсэн саналаар санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|            |    |
|------------|----|
| Зөвшөөрсөн | 10 |
| Татгалзсан | 11 |
| Бүгд       | 21 |

47.6 хувийн саналаар буюу гуравны хоёроор дэмжигдсэнгүй.

**Ц.Даваасүрэн:** 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад өөрчлөлт оруулах зорилгоор Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх гэснийг хасах гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал тайлбар хийв.

|            |    |
|------------|----|
| Зөвшөөрсөн | 12 |
| Татгалзсан | 9  |
| Бүгд       | 21 |

57.1 хувийн саналаар буюу гуравны хоёроор дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.*

**Зургаа.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлд “Шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмын дагуу хэлэлцэн баталж болно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж ирүүлснийг танилцуулав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Тогтоолын төслийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ц.Даваасүрэн:** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|            |    |
|------------|----|
| Зөвшөөрсөн | 13 |
| Татгалзсан | 8  |
| Бүгд       | 21 |

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Дэлгэрмаа, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Мөнхсоёл, Ж.Баясгалан нар үг хэлэв.

**Ц.Даваасүрэн:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|            |    |
|------------|----|
| Зөвшөөрсөн | 18 |
| Татгалзсан | 5  |
| Бүгд       | 23 |

78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.*

*Хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, 25 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 92.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 55 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр.  
Баасан гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхимд  
09 цаг 15 минутад эхлэв.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Даваасүрэн:** Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс ирсэн 15 гишүүн, ирц 60 хувьтай байна. Тийм учраас Төсвийн байнгын хорооны 7 сарын 4-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Хуралдаанд ирсэн гишүүдийг би та бүхэнд танилцуулъя. Т.Аубакир гишүүн, Ж.Батжаргал гишүүн, П.Ганзориг гишүүн, Г.Дамдинням гишүүн, Д.Пүрэвдаваа гишүүн, Д.Цогтбаатар гишүүн, Д.Батбаяр гишүүн, Д.Батлут, гишүүн, Х.Ганхуяг, гишүүн, Б.Заяабал, гишүүн, Г.Тэмүүлэн гишүүн, Р.Батболд гишүүн, Х.Болормаа гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, Б.Түвшин гишүүн нар хуралдаанд оролцохоор бүртгүүлсэн байна.

Өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя.

Эхний асуудал Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

2 дугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд 3 дахь хэлэлцүүлэг байгаа.

3 дахь асуудал, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг байгаа.

4-т, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын мэдүүлсэн хуулиуд Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд эцсийн хэлэлцүүлэг.

5-д, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, мэдээллийн анхны хэлэлцүүлэг.

6-д, Тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх байгаа. Энэ тогтвортой байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэхэд шалтгаантайгаар одоо чөлөө авсан эсвэл өвчтэй байгаа гишүүдээс бусад бүх

гишүүд оролцох ёстой юм байна лээ шүү. Тийм учраас энэ гишүүдээ 6 дахь асуудлыг хэлэлцэхэд оролцуулах арга хэмжээг авахыг анхаараарай манайхан.

За энэ 6 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байна. Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

За нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Э.Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Х.Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга, И.Баттөгс Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх гэсэн ийм хүмүүсүүд оролцож байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх хуультай. Нийслэлийн Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? алга байна. Энэ зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Энэ зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүн танилцуулсан бүрэлдэхүүн хэвээрээ байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэнэ. 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Энэ зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх эдгээр хуулиудын шүү явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд манайхаас төрийн байгуулалт хэн байгаа юм. Манай байнгын хорооноос. Болормаа гишүүнээр уншуулъя. Болормаа гишүүн Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулна.

09:22

**Ц.Даваасүрэн:** Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг эхэлье ээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Н.Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Д.Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна аа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн талаарх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгье. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн танилцуулах хүн байна уу? энэ ажлын хэсэг нь Ганхуяг билүү энэ дээр. За тэгвэл төсвийн хүрээний мэдэгдлийг Ганхуяг гишүүн танилцуулна аа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

09:24

**Ц.Даваасүрэн:** Дараагийн асуудалдаа орёе.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсэг Б.Жавхлан Сангийн сайд, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Д.Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, О.Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга. Энэ дарга юм байгаа биз дээ бичээгүй юм байна тиймээ. Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгдсэн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Б.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга гэсэн ийм хүмүүсүүд оролцож байна аа.

Нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусгах эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбартай холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрийг авъя байна уу? За Номинчимэг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

**О.Номинчимэг:** Өглөөний мэнд гишүүд ээ, Төсвийн 3 дугаар хэлэлцүүлэг гэж ойлгож байгаа зөв үү Даваасүрэн дарга аа. Энэ өчигдөр чуулган дээр ингээд нэг баахан санал босчихсон шүү дээ. Тэгээд энэ дэгээрээ байна уу энийг асуумаар байгаа юмаа. Энэ Гонгорын Ганбаатар гишүүн Нийслэлийн боловсролын газрын төсвийг аваад хааш нь тавьчихлаа. Үгүй ээ энэ одоо Нийслэлийн боловсролын газрын урсгал зардлаас 2.6 тэрбумыг бууруулаад, Цахим хөгжил, инновац холбооны сайдын урсгал зардал нэмсүгэй гэнэ ээ. Энэ яг ямар санал юм бэ? Энэ нийслэлийн боловсролын насаараа ажилласан багш нарын тэтгэмжээс хумслаад

Цахим хөгжлийн яам руу санал гаргаж байгаа энэ Гонгорын Ганбаатар гэдэг гишүүн өөрөөсөө ичих хэрэгтэй шүү дээ. Яагаад ийм санал гаргадаг юм бэ? Тэгээд яагаад энэ чуулган дээр босдог юм бэ АН-ынхан. Ийм муухай зарчимгүй юм хийж болохгүй шүү дээ та нар. Яа гэж байгаа юм тэр багш нар луу. Тэр багш нарын өөдөөс хараад та нар өөрсдөө хараад тэрийгээ хэлж чадах юм уу? Дэгээрээ энийг яаж янзлах боломж байгаа юм байнгын хорооны дарга аа.

3 дугаар хэлэлцүүлэг дээр энийг гишүүн нь саналаа татаж авах ёстой юм уу, яах ёстой юм.

**Ц.Даваасүрэн:** Номинчимэг гишүүн ээ, сая би наад асуудлаар чинь ингээд Тамгын газраас бас хуулийн лавлагаа авлаа. Дэгийн тухай хуулийн 72.2-оор нэгдсэн хуралдаанаар 3 дугаар хэлэлцүүлэг явахад зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар гишүүд тайлбар хийж, түүнтэй холбогдуулан асуулт асуух бөгөөд санал хураалт явуулахгүй гэнэ ээ. Тэгэхээр санал хураалт байдаггүй юм байна. Нөгөө 3-ны 2-оор болох юм болов уу гэсэн болохгүй юм байна. За Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

**О.Номинчимэг:** Одоо ийм сонин байдал руу бид нар улс орныгоо, тэгээд ялангуяа энэ боловсролын салбар, эрүүл мэндийн салбараа түлхмээргүй байна аа. Энэ Гонгорын Ганбаатар гэдэг гишүүн ирж өөрөө эндээ тайлбараа хийх хэрэгтэй. Яг ямар зорилгоор энэ багш нарт өгөх мөнгийг аваад Цахим хөгжлийн яам руу өгч байгаа гэдгээ тайлбараа хийх хэрэгтэй. Гомбын Ганбаатар АН-ын, хөдөөгөөс сонгогдсон юм байна лээ. Тэгэхээр тэр хүнд нийслэлийн багш нарын асуудал хамаагүй гэж үзэж байгаа юм байгаа биз. Ичих хэрэгтэй.

Тэгээд энэ дээр тэгвэл одоо Сангийн яамнаас протоколд үлдээх зорилгоор яг энэ Нийслэлийн боловсролын газраас хасаж байгаа 2.6 тэрбум юуг нь хасаад Цахим хөгжлийн яам руу урсгал зардал руу өгчхөж байгаа юм. Тэрийгээ нэг тайлбарлаад өгөөч гэж хүсмээр байна. Ажлын хэсгээс. Би асуулт асууж болно шүү дээ 3 дугаар хэлэлцүүлэг дээр гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Саяын Номинчимэг гишүүний яриад байгаа асуудал болбол бас зарчимгүй л зүйл болчихсон байгаа байхгүй юу. Одоо ингээд 100 гаруй багш тэтгэвэртээ гараад авдаг тэтгэмжээ авч чадахгүй болчихож байгаа юм байна лээ. Өөр ер нь нэг байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг нөгөөд шилжүүлнэ гэдэг бол бас утгагүй асуудал л даа. Тэгээд өчигдөр одоо ингээд энэ санал хураалт чуулганаар дэмжигдээд ингээд явчих юм. Тэгэхдээ бас энэ юу Г.Ганбаатар гишүүнээс илүү бас бид өөрсдөө буруутай байхгүй юу. Энэ саналыг нь дэмжихсэн байна шүү дээ гишүүд, тийм дэмжихсэн байгаа байхгүй юу.

Тийм учраас би чуулганы хуралдаанд хэлсэн шүү дээ, морь унасан толгойгүй хүн шиг битгий байгаад бай л даа та нар анхаараач ээ гээд зөндөө л хэлсэн шүү дээ. Тэгээд одоо ингээд бүгдээрээ хамтдаа шийдчихээд нэгнийгээ буруутгаад байлтай нь биш тиймээ. Уг нь нэг нь буруу шийдвэр гаргавал бид нар чинь хамтаараа тэрийг нь нурааж байх ёстой, зөвшөөрөхгүй байх ёстой, гэтэл нэгнийхээ гаргасан алдааг олонхоороо дэмжээд явчихсан байгаа байхгүй юу.

Тэгээд энийгээ одоо бас Их Хурлын гишүүд жоохон анхааралтай хандахгүй болбол ингээд 100 гаруй нийслэлийн багш нарын асуудлын одоо хүний хувь заяаны асуудал шүү дээ насаараа төрдөө хөдөлмөрлөчхөөд, тэгээд одоо насны тэтгэврээ аваад гарахдаа авдаг тэтгэмжийг нь аваачаад хасаад хаячхаж байгаа байхгүй юу.

Тэгэхдээ энийг ер нь залруулж буцааж олох чиглэлээр анхаарах хэрэгтэй. Тэгэхгүй бол болохгүй. Уг нь олгоно зүгээр гэхдээ энэ жилдээ хөрөнгө нь байхгүй болчих гээд байна шүү дээ. Тэгэхээр энийг хэдүүлээ бас жоохон анхааръя аа. Хэнээс авах юм. Сангийн яам энэ хэлэлцүүлэг дээр чинь. Сангийн сайд тайлбарлах юм уу тэгээд? За нэг номер, нэг номерын микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Өчигдрийн санал нь болбол яг үг, үсгээр юу гэж байсан гэхлээр Нийслэлийн боловсролын газрын урсгал зардлаас гээд томьёолчихсон юм байна лээ 2.6 тэрбум төгрөгийг хасна гээд. Бид бол Нийслэлийн боловсролын газрын төсвийг бол үзсэн. Уртаашаа 2.6 тэрбум төгрөгийн төсөвтэй юм байна лээ. Цалин нь бүгд ороод. Тэгээд нөгөө эхний хагас жилдээ уже талыг нь аваад явчихсан. Тэгээд сая нөгөө хэмнэлтийн тогтоолоор болохлоороо бичиг хэрэг бүх зардлууд нь хасагдсан учраас ерөөсөө үлдэж байгаа зардал нь бол 1 тэрбум гаруй төгрөгийн цалин л үлдсэн байна лээ. Тэгэхлээр нөгөө цалинг нь хасахлаар болбол энэ байгууллага өөрөө татан буугдах гээд байгаа учраас яах аргагүй үлдэж байгаа ганцхан зардал үлдэж байгаа. Тэр нь болбол багш нарын тэтгэвэрт гарахдаа авдаг 36 сарын тэтгэмж.

Тэгэхлээр тэндээсээ л хасаад явчхаж байгаа юм. Бид Их Хурлаас гарсан шийдвэрийн дагуу л хасаад сууж байна.

**Ц.Даваасүрэн:** Энэ зүгээр салбарын зохицуулалтаар Боловсролын сайд зохицуулалт хийгээд дараа нь төсвөө төсвийн хууль өргөх энэ тэр шийдээд явах боломж бий юу?

**М.Санжаадорж:** Энэ удаа болбол бид нар Их Хурлаас гарсан шийдвэрийг л шууд биелүүлэх ёстой, тэр дагуугаа л биелүүлсэн. Тэтгэвэрт гарч байгаа хүмүүсийн нэр ус, тоо болбол бүгд нэр усаараа регистрээрээ орж ирдэг учраас дараа нь зохицуулалт хийхэд бол хүнд байх аа.

**Ц.Даваасүрэн:** Ирэх жилийн төсөв дээр ч юм уу суулгаад явбал.

**М.Санжаадорж:** Ирэх жил дээр л суухаас өөр аргагүй. Тэгэхдээ ингээд хагас жил одоо хүлээхээр л байгаа.

**Ц.Даваасүрэн:** Энийг нь анхаараарай. Хариулт дутуу байвал 1 гишүүн, нэг минут нэмдэг. Номинчимэг нэг минутыг нь өгье.

**О.Номинчимэг:** Тэгэхээр чинь одоо ингээд төрийн албаны тухай хуулиараа тэтгэвэрт гарч байгаа бид нар багш нартаа 20, 30 жил ачаалалтай ажил хийлгэж байна 30 сарын тэтгэмж өгдөг юм шүү дээ. Тэгээд тэрийг нь бүгдийг нь Цахим хөгжлийн яамны урсгал зам зардал руу авъя гэж байгаа юм байна шүү дээ. Энэ чинь нэг утгаараа ингээд бид нар чуулган дээр 2 дугаар хэлэлцүүлэг дээр санал хураагдчихлаа гэж байгаа биш нөгөө утгаараа төрийн албаны тухай хуулиа биелүүлэх энэ хуулиа зөрчөөд байна шүү дээ. Хуулийн зөрчилтэй, үүргээ төр өөрөө үүргээ хуулиа зөрчих юм орж ирж байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь хууль хоорондын зөрчил мөн биз дээ.

Одоо хууль хоорондын зөрчил хэрэгжих боломжгүй гэдгээр нь дахиад энийг хууль зүйн дүгнэлт гаргаад, санал хураалгах саналтай байна аа. Ийм одоо асуудлууд бас зөндөө л байгаа шүү дээ. Бид нар Төрийн байгуулалтын хороон дээр

хууль хоорондын зөрчил гээд л дүгнэлт гаргаад энэ асуудлуудыг хөндөөд явж байгаа. Энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газар дэгээ хараад, хууль хоорондын зөрчил, хуулиа зөрчих нөхцөл өөр бий болгож байгаа учраас энэ дээр дүгнэлт гаргуулж байгаад дахиад хэлэлцүүлгээ хийж энэ асуудлыг засах хэрэгтэй байна аа. Энэ төсөв батлагдахаас өмнө.

**Ц.Даваасүрэн:** Ингээд бид нар чинь нөгөө төсвийн тусгай дэгээр хэлэлцэнэ шүү дээ. Нэг номерын микрофон.

**Х.Батжаргал:** Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал мэдээлэл өгье өө тайлбар. Энэ Нийслэлийн боловсролын газрын төсөв зөвхөн нэг байгууллагын төсөв гэж харагдаж байгаа боловч нийт 972 байгууллага, 40 мянга 772 багш, ажилтан албан хаагч, 525 мянга 776 хүүхэд цэцэрлэгийн одоо 1 сая 51 мянган хүүхэд. Энэ олон албан хаагчид иргэдийн одоо зохион байгуулалт, зохицуулалт бодлогын хэрэгжилт хангагдаж явж байгаа. Тэгээд энэ хасагдаж байгаа гэж байгаа төсөв дотор хэрвээ хасахаар ингэж шийд гарвал 117 орчим багш, албан хаагчдын тэтгэмж олгогдох боломжгүй нөхцөл байдал үүсчхээд байгаа юмаа.

Тэгэхээр өнөөдөр 6 сарын 25-ны байдлаар бол 15.2 тэрбумын тэтгэмж одоо ингээд...

**Ц.Даваасүрэн:** За ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал байхгүй юм байна. Энэчээ юу нөгөө тусгайлсан дэгтэй учраас бүр санал хураалт байхгүй энэ тэр гээд яг ингээд заачихсан учраас санал хураалтаар зохицуулах ямар ч боломжгүй юм байна. Дэгийн тухай хуулийн 72.2-оор зөвхөн асуулт асууж, хариулт авна гээд ингэчихсэн. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 3 дугаар хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд за би танилцуулчихъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар хэлэлцүүлэг дууслаа.

Тэгэхдээ гишүүд ээ, энэ зүгээр 3 дугаар хэлэлцүүлгээр бид нар ямар ч санал хураалт явуулах боломжгүй болоод ингээд хязгаарлагдчихаж байна. Гэхдээ тэр нэг багш нарын тэтгэмжийн асуудлыг бас хэдүүлээ одоо ирэх жилийн төсөвт суулгах энэ бүх арга хэмжээг нь авч өгөхгүй болбол бас насаараа зүтгэсэн улсуудын урмыг хугалж болохгүй. Тэгэхээр энэ дээр би өөрөө протоколд тэмдэглэж үлдээе. Энэ олон гишүүдийн гаргаад байгаа саналыг бас анхаарах ёстой.

09:37

**Ц.Даваасүрэн:** 4 дэх асуудалдаа орёё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя аа.

Ажлын хэсэг хэвээрээ юу? Өөр үү. Жаахан өөрчлөлт орчихсон юм байна. Б.Жавхлан Сангийн сайд, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн дарга, Б.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга гэсэн хүмүүс оролцож байна.

Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг хууль, тогтоолын төслүүдэд нэмж тусгаад, төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн бэлтгэсэн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа.

За энэ хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хувилбартай холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Асуухаасаа кнопоо дар, нэрээ өгнө. Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн.

**Х.Ганхуяг:** Алт 3 аяныг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим арга хэмжээний тухай өчигдөр олонхын дэмжлэг аваад дэмжигдсэн тул энэ дээр нэг зарчмын зөрүүтэй санал гаргахгүй болохоо больчихоод байгаа юмаа. Энэ дээр Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх суурь зарчимд нийцээгүй. За Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд зааснаар АМНАТ-ын 30 хувийг тухайн орд байрлаж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт хуваарилагдахаар. Төсвийн тухай хуульд зааснаар тухайн орон нутагт олборлож борлуулсан АМНАТ-ын 30 хүртэлх хувийг орон нутгийн төсөвт хуваарилахаар заасан байгаа.

Тийм учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу 1 дүгээр тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээх гэснийг хасуулахаар санал гаргаж байгаа юмаа.

**Ц.Даваасүрэн:** Эхлээд яах вэ асуултаа асуучихна. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналаа өгнө. Хэрвээ зарчмын зөрүүтэй саналыг гишүүдийн 3-ны 2 нь хураах нь зүйтэй гэж үзэх юм бол хурааж болно. Тэгэхээр би энэ асуулт дууссаны дараа зарчмын зөрүүтэй саналуудаас санал хураалт явуулна. За Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Дагасан хууль тогтоомжийн төсөл дээр дам дамаа тэр Алт 3-тай холбогдуулаад 2 асуудал байгаад байгаа юмаа. Нэг нь тэр сая яригдлаа. Үр өгөөжийн дийлэнх нь тухайн

сумандаа үлдэхээр одоо нэмэлт санал гаргаад тэр нь Төсвийн байнгын хороон дээр унасан байсан нь өчигдөр чуулган дээр босчхож байгаа юм. Тэгэхээр энэ үндсэндээ Үндсэн хуулийн үзэл санаа нь ч тэр, Баялгийн сангийн хууль энэ бүх хуультайгаа зөрчилдөөд байгаа ийм зүйл байгаа юмаа. Тийм учраас би одоо энэ заалтыг хуульд нийцүүлэх үүднээс өчигдрийн тэр ажлын хэсгийн гаргасан нэмэлт томъёоллыг нь хасуулах ийм саналтай байна аа ингэх одоо бололцоо боломж нь ямархуу байна вэ? сайд юу гэж үзэж байна вэ гэдэг ийм асуулт байна.

2 дахь нь алтны олборлолтыг нэмэгдүүлэх Монгол банканд тушаагдах алтны нөөцийг нэмэгдүүлэх бодлого чиглэл бидний эрхэм зорилго байгаад байгаа үнэн. Гэхдээ заавал хэвлий нээж олборлож байх албагүй ээ. Өнөөдөр ашиглагдаж байгаа стратегийн шинж чанартай ордуудын чинь олборлолт баяжуулалтын үйл явц дунд лабораториудын сорилтын үр дүнгээр ер нь Монгол Улсын 2 жилд бүрдүүлэх хэмжээний алтны хэмжээ баяжмалын шалаан буюу үүсмэл ордонд үлдсэн байна гэдэг ийм тов тодорхой дүгнэлт гарч ирээд байгаа юмаа. Тэгвэл энүүнийгээ нэн тэргүүн ээлжид ашиглая л даа тэгээд.

Тийм учраас би энэ тогтоолын төсөлд орж ирээд байгаа тэр Их Хурлын тогтоолын дугаар заачхаад байгаа нэмэлт одоо ажлын хэсгийн томъёоллыг хасуулмаар байгаа. Харин одоо нэмэлт юм орно гэж үзэж байгаа бол тэр үүсмэл ордуудаа нэн тэргүүн ээлжид ашиглах хэрэгтэй. Зардал багатай тэгээд илүү дутуу зөвшөөрөл янз бүрийн юм нэхээд явахгүй, угаасаа хэвлий нь хөндөгдчихсөн газар дээр үүссэн овоолго учраас тэр дотроос авах ёстой юмаа авчих нь зөв байгаад байна. Энэ нь Монгол Улсын эрх ашигт нийцэж байна гэж би ингэж үзээд байна. Энэ дээр одоо сайд ямар бодолтой байгаад байгаа юм. Энэ дээр нэг тодорхой хариулт авчихъя.

Дараагийн нэг зүйл байна. Бид одоо тусгай зөвшөөрөл эзэмшигчдээ бүх талаар дэмжилгүй яах вэ. Тэгж байж тогтвортой үйл ажиллагааг нь явуулна. Гэтэл орон нутгийн уугуул иргэд гэдэг юм уу, уламжлалт аж ахуйгаа эрхэлж байгаа иргэдтэйгээ бас нэг тийм төрийн төмөр нүүр гаргаж ажиллах тухай...

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүний асуултад Дамдинням сайд хариулъя.

**Г.Дамдинням:** Батжаргал гишүүн болон одоо манай бусад гишүүд бас нэлээн чухал асуудал яриад байгаа үнэн. Тэгэхдээ яах вэ ийм л юм байгаа юм. Бид нар Алт 3 аяны хүрээнд эхний ээлжид 3 үндсэн ордын асуудал ярьж байгаа юм. Хуучин болбол нийт гишүүдийн одоо нийт одоо алтны нөөцтэй холбоотой асуудал ингэж ийм тодорхой бусаар орж ирээд шороон ордууд ашиглагдаад, байгаль орчин гол усыг сүйдлээд, нутгийн ард иргэдийн дургүйцлийг төрүүлээд ингээд явдаг байсан.

Тэгээд бид болбол энэ удаад маш тодорхой Их Хурлаас тодорхой байрлалыг нь координацыг нь заачихсан эрх Засгийн газарт өгөөч ээ гэдэг ийм л одоо хүсэлт тавиад байгаа юм. Энэ эрх нь өөрөө Засгийн газарт байгаа юм. Энд орж ирж байгаа Алт аяны 1 дүгээр хэсэг дээр орж ирж байгаа энэ 3 үндсэн ордын асуудал болбол үндсэндээ шууд олборлолт хийгээд, одоо баяжуулалт хийгээд явахад бэлэн болчихсон. Үйлдвэрээ барьчихсан за тэгээд тодорхой хуулийн хязгаарлалтад орчихсон байгаа энэ л одоо ордуудыг тухайн газар нь олон улсад сүүлийн үед бий болсон шинэ технологиуд бас шинэ эрх зүйн орчнуудаас одоо Монголын эрх зүйн орчин суулгаж байгаад одоо ашиглая аа гэдэг ийм л одоо байр суурь илэрхийлж байгаа.

Энэ нь юу вэ гэхээр байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын баталгаа болох одоо мөнгө, санхүүгийн эх үүсвэрийг урьдчилж авч байгаад, олон улсын стандартад нийцүүлж, байгальд хамгийн багаар одоо хор хөнөөл учруулах энэ технологийг ашиглаж одоо олборлох боломжтой юмаа л гэж бид үзэж байгаа. Тэгээд энэ дээр болбол одоо тодорхой чиглэл өгөөч ээ гэсэн ийм л одоо хүсэлттэй байгаа. Ний нуугүй хэлэхэд нүүрсний үнэ 140 доллар байсан. Одоо 70 хүрэхгүй доллар байна. Бидний орлого 50 хувь унаж байна. Эдийн засаг явахгүй, долларын ханш өснө, төгрөгийн ханш унана, оны эцэст инфляц өндөрт хүрнэ. Энэ ард иргэдийн нуруун дээр ирэх эдийн засгийн хүндрэлтэй ачааг болиулъя аа л гэж одоо ярьж байгаа. Түүнээс биш одоо тухайн алтны ордын тухай асуудал энд ерөөсөө байхгүй байхгүй юу. Тэгэхээр эдийн засгаа явуулъя, цалин тэтгэврээ тавья, хүүхдийн мөнгөө өгье гэж бодож байгаа болбол бид нар энэ эдийн засгийнхаа энэ хүчин чадлыг шавхахаас өөр аргагүй болчхоод байгаа юм. Ийм л одоо нөхцөл байдалтай байгаа учраас бид нар энэ төслийг оруулж ирж байгаа. Тэгээд та бүхэн маань одоо өчигдөр бас Их Хурал дээр дэмжээд тодорхой ингээд оруулаад өгчихсөнд их баярлаж байгаа.

За өнөөдөр болбол одоо энэ дээр ямар нэг өөрчлөлт оруулахгүй байж өгөхийг бас гишүүдээс хүсье ээ.

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

**Б.Мөнхсоёл:** Би бас энэ Батжаргал гишүүний хэлсэнтэй санал нэг байгаа. Дийлэнх өгөөжийг үлдээх гэдэг нь өөрөө өчигдөр бас нэг гишүүн хэлж байсан. Дийлэнх гэдэгт яг хэдэн хувийг хэлж байгаа юм. 50 нэмэх 1 юм уу, одоо 60 нэмэх 1 юм уу гээд тиймээ. Энэ дээр тодорхой байхгүй бол угаасаа хариуцлагатай уул уурхай яриад удсан. Үндэсний баялгийн сан гэх мэт тиймээ бүр анх болбол бид нар Ирээдүй өв сан гэдэг хоосон сангууд бий болгосон шүү дээ. Одоо тэгээд л төсөв дутагдахаар л хадгалж эхэлж байсан нэг цөөн тооны мөнгөө хэрэглээд эхэлчихдэг. Тэрэн шиг одоо хэрэглэе, одоо зарцуулъя гэдэг хандлага нь өөрөө өрөөсгөл болчхоод байгаа юмаа. Төсвийн сахилга бат, төсвийн оновчтой зарцуулалт, төсвийн одоо үр өгөөжтэй байдал чинь байнгын жил болгон асуудалтай байдаг.

Яагаад вэ гэхээр одоо яагаад бид нар ийм байдалд ороод байна вэ гэхээр төсвийн орлогыг хэт өөдрөг төсөөлдөг гэдгийг хүлээж авахгүй юмаа гэхэд эрдэс баялгийн үнэ, нүүрсний үнэ гэнэт таамаглахын аргагүй уначихдаг юмаа гэхэд зарцуулалт, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараа, урсгал зардлын оновчтой одоо шийдэл энэ тэр чинь алдагдсаар олон жил болчихсон байхгүй юу. Зөвхөн энэ 126-д ч юм уу, энэ засагт буруутай гэж үзэхгүй байна. Энэ чинь олон жил хуримтлагдчихсан төсвийн бодлого реформ хийгдэхгүй алдагдсан бодлого.

Одоо энэ 126 орж ирээд өөрчилъе, шинэчилъе гэсэн чинь эхний жил нь төсвөө одоо хэдэн ч удаа хэлэлцээд, дандаа хуумгай, дандаа яаруу, хүмүүс нь юмаа уншиж судлаагүй дэмжчихсэн Дамдинням сайд аа, ойлгосондоо дэмжээгүй ээ, мөнгө хэрэгтэй юу хэрэгтэй гэдэг чинь хангалттай гэж үзэхгүй байна аа. Тэгэхээр нухацтай хандах ёстой гэсэн байр суурьтай байна. Тэгээд би энэ дийлэнх гэдгийг хэд гэж төсөөлж байгаа юм гэж тодорхой асуумаар байна.

**Ц.Даваасүрэн:** Хариулт авах юм уу Дамдинням гишүүн, сайд хариулъя.

**Г.Дамдинням:** Тийм, яах вэ энэ тогтоолын төсөл дээр яригдаад байгаа нэг 2 асуудал байгаа юм. 1 дүгээрт тэр засах чиглэл өгөөч ээ гэдэг. Тэрэн дээр бол би

түрүүн хариулт хэлчихлээ. Энэ байгалийн баялгийн үр өгөөжийг тухайн газар оронд нь бас тодорхой хэмжээнд үлдээгээд өгөөч ээ гэдэг одоо энэ манай Уянга гишүүний гаргасан санал болбол уг нь зарчмын хувьд зөв болчихоод байгаа юм. Өөрийнх нь санаачлаад явж байгаа хуулийн үзэл санаатай ч таараад байгаа юм. Гэхдээ Үндсэн хуультай зөрчилдөөд ингээд явж байгаа болбол одоо гишүүд өөрсдөө мэдээд саналаа өгөөд яваач ээ, явах нь бол бүрэн эрх байх аа. Зүгээр гол асуудал нь юун дээр байгаад байгаа вэ гэхээр байгаль өөрийнхөө амьдран сууж байгаа орчин, одоо тэр хэдэн мянган жил нутагласан газар орноо ухуулж төнхүүлчхээд, бусад аймгуудад, бусад газар оронд ухуулахгүй байгаа хүмүүстэй ижилхэн АМНАТ буюу одоо ашигт малтмалаа ухуулсныхаа нөөцийн төлбөрийг аваад байгаадаа ард иргэд бас дургүйлхээд байгаа байхгүй юу. Бид нар ухуулж байна. Ухуулаад байгаа мөртөөсөө бусад газар орнууд ухуулахгүй.

Бид нар одоо жишээ нь уул уурхайгүй тэр тэр аймаг гээд ярьдгийг бүгдээрээ мэднэ. Гэтэл энэ аймгуудтай яг ижилхэн төсөв аваад сургуулийнхаа асуудлыг, цэцэрлэгийнхээ асуудлыг, эрүүл мэндийнхээ асуудлыг шийдэж чадахгүй байна аа. Тийм юм бол бид нар яагаад ухуулах ёстой юм бэ гэдэг ийм л асуудал яриад байдаг юм. Тэгэхээр энийг болбол ер нь зүгээр бодоход Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Татварын хуулиуд гээд энэ тэгээд бас хөрөнгө оруулалтын хуулиуд гээд энэ багцаар нь бид нар нэг яриад, шийдэх ёстой юм байна лээ. Өнөөдөр энд ингээд орчхоод байгаа энэ заалт дээр болбол би бас гишүүдтэйгээ ижилхэн л бодолтой байгаа. Тэгээд одоо энэ зарчмын зөрүүтэй санал гараад явж байгаа болбол одоо харъя. Тэгээд ийм л байна.

**Ц.Даваасүрэн:** Дутуу хариулсан гэж үзэж байгаа юм уу? За тодруулъя Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Энэ асуулт жоохон Дамдинням гишүүн бүрхэг ойлгоод, бүрхэг хариулчих шиг боллоо. Миний гол санаа зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа Ганхуяг гишүүнтэй санал нэг байгаа. Гарын үсгээ зурчихсан.

2 дугаарт тэр баялагтай орон нутаг нь, сум нь, аймаг нь илүү өгөөжөө авах ёстой гэдгийг бид нар олон жилийн өмнөөс мэдчихсэн шүү дээ. Тэрийг чинь мэдээд, ойлгоод орон нутгийн хөгжлийн сангийн орон нутагт мөнгө хуваарилах, төсөв хуваарилахдаа 4 гол шалгуур үзүүлэлт байгаагийн нэг нь ашигт малтмал нь шүү. Тэрний өгөөжийг тооцож байгаа. Тэгээд Үндэсний баялгийн сандаа бас тооцож байгаа. Энэ чинь томъёо явж байгаа. Нэг ухраад, нэг буцаад, нэг ухраад 30 хувь, 10 хувь явсан тиймээ Санжаа. Энэ асуудал биш ээ. Яг энэ төсвийн тодотгол ярьж байгаа богино хугацаанд том том асуудал, том том эрхийг хязгааргүй өгч байгаад дургүйцэж байгаа ийм л асуудал байгаа. Тэгээд Үндсэн хуулийн асуудал яригдаж байгаа.

Төсөв алдагдах гээд байгаа учраас байгаа алтныхаа нөөц ордыг ашиглая гэж оруулж ирчхээд одоо гэнэт нэг их ард түмэнд хайртай болоод, нутаг усанд нь хайртай болж явахгүй ээ. Хүмүүс юм ойлгож байгаа. Мушгиж хариулахгүй шүү.

**Ц.Даваасүрэн:** Асуусангүй шүү дээ. За Дамдинням гишүүн хариулъя, Дамдинням сайд хариулъя.

**Г.Дамдинням:** Мөнхсоёл гишүүн маань одоо яах вэ зүгээр би нөгөө нэг төсөвтэй холбоотой асуудал дээр юм хэлээгүй учраас та бүрхэг гэж бодоод байх шиг байна. Тэгээд төсөвтэй холбоотой асуудал дээр бас Сангийн сайд, Сангийн

яамныхан маань хариулна биз. Би зүгээр өөрийнхөө салбарын зарчмын асуудлыг л хэллээ нэг. 2 дугаарт энэ алтыг төсөв дутсан учраас ухаад байгаа юм ерөөсөө байхгүй. Энэ явж явж оны эцэст энэ зүгээр мөнгөний бодлого дээр илүү нөлөөтэй л ажил шүү дээ. Ханшаа барья, валютын нөөцөө нэмэгдүүлэе ийм л бодлого. Ер нь болбол бид нар алтан дээр суусан гуйлгачин гэдэг нэрээ бол зүүгээд яваад байж болохгүй. Байгальд ээлтэй зөв технологиор ашиглаж, ард иргэдийнхээ энэ нуруун дээр ирж байгаа энэ маш тогтворгүй байгаа дэлхий даяар байгаа энэ эдийн засгийн нөхцөл байдлыг даван гарахад нь л нэмэр болъё л гэсэн үг. Хүнд үед бид нар өөрсдийнхөө нөөцийг ашиглахаас өөр гарцгүй байхгүй юу. Ийм л юм. Өөр юм бол яриагүй.

**Ц.Даваасүрэн:** За яах вэ дээ дэгээрээ бол эцсийн хэлэлцүүлэг дээр гишүүд санал гаргаж болно. Саналыг 3-ны 2 дэмжих юм бол хураалгана. Тийм учраас наад санал чинь тэгээд одоо гишүүд дэмжих эсэхийг хэдүүлээ санал хураалтаараа шийднэ ээ. Түвшин гишүүн асуултаа асууя.

**Б.Түвшин:** Тэгэхлээр төсвийн орлогыг тооцохдоо хэдүүлээ тэнцвэржүүлсэн үнээр тооцдог. Ялангуяа энэ уул уурхайн баялаг үнэтэй холбоотой асуудлыг тэнцвэржүүлсэн үнээр тооцно оо гэдэг нь хэлбэлзсэн үед нь нэг их дагаад хэлбэлзээд байхааргүй тийм нөөц сан бүрдүүлэх гэсэн агуулгаар явж байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр бол уул уурхайн баялгийн үнэ унаад нэг 6 сар болж байна. Тэгээд энэ хооронд одоо тэр нөгөө тэнцвэржүүлсэн үнээр тооцоод байсан зөрүүнүүд нь байгаа юм уу? Тэрийг ер нь яаж ингээд хэлбэлзүүлээд байгаа юм?

2 дугаарт өнгөрсөн 7, 8 жил тасралтгүй уул уурхайн үнэ, түүхий эдийн үнэ өсөж ирсэн. Түүхэндээ байгаагүй хэмжээний их орлого зардалтай байж ирсэн. Өнөөдөр ингээд огцом буурчихад бид нар ийм их сандарч одоо бүүр бүх газар дэлхийгээ ухаж алт малт руугаа орох ийм шаардлага байгаа юм уу? Нөгөө нөөц баялаг сангууд нь одоо хэр их байдаг юм. Энэ ер нь тэнцвэржүүлсэн үнийн одоо төсвийн орлогыг тооцож байгаа аргачлал ер нь зөв байна уу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах юм. Жавхлан сайд хариулъя. Тэр нөгөө заавал одоо газар баялгаа гэснээс илүү өөр сан мангаа ашиглаж болдоггүй юм уу гэсэн асуулт байсан юм. Яагаав нөгөө нэг тогтвортой байдлын сан гээд л нөгөө нэг үнэ нь унахаар ашиглана, өсөхөөр яана гээд байгаа тэрийгээ хэрэгжүүлэх асуудал.

**Б.Жавхлан:** Тийм тийм. За Түвшин гишүүний асуултад хариулъя. Тэр Тогтворжуулалтын сан бол бас зүгээр нэг орлого уначихсан үед бараг хэрэглээд байх тийм энгийн зохицуулалттай биш шүү. Тийм нэлээн аягүй босго өндөртэй байгаа. За тэрийг нөгөө хуулийн заалтуудыг Санжаа хариулаадхаарай тийм. Энэ жил л лав бид нар хүрч чадахгүй тийм хэмжээнд бас муудаагүй байгаа. Тэгээд хуулийн заалттай ийм байгаа. За тэрнээс биш бусад бид нар эргэлтэд оруулах энэ байгалийн баялгуудыг байгаль орчин болон бусад тэнцвэртэй бодлогуудаа хадгалаад бид одоо орох л хэрэгтэй тийм.

**Ц.Даваасүрэн:** За ажлын хэсэг 6 номер Санжаадорж тодруулъя. Тогтворжуулалтын сангийн хөрөнгийг ямар нөхцөлд зарцуулах вэ гэдэг дээр хариулъя за юу. За 6 номер.

**М.Санжаадорж:** Тогтворжуулалтын санг болбол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар хуульчилж зохицуулалтыг заасан байдаг. Өнөөдрийн

байдлаар үлдэгдэл бол 2 их наяд төгрөг Тогтворжуулалтын санд бол хуримтлагдсан байж байгаа. Энэ мөнгийг хэзээ зарцуулах вэ гэхлээр төсвийн алдагдал батлагдсан хэмжээнээс ДНБ-ий 4 хувиар нэмж буурахад буурсан тохиолдолд. Энэ үед бол ямар байдлаар ашиглах вэ гэхлээр бүгдийг нь бас ашиглачихгүй. Зөвхөн одоо тэр тогтворжуулалтын санд хуримтлуулж байгаа одоо манайхаас бол хуримтлуулж байгаа нь бол нөгөө орлогын нийт орлогын 3 хувиас дээш гэдгээрээ нүүрс, зэс 2 хуримтлагдаж байгаа. Нүүрс, зэсийн тэнцвэржүүлсэн үнээс доошоо орсон эсэхийг л одоо тэнд хуримтлуулна аа гэдэг ийм заалттай байгаад байгаа юм. ДНБ-ний хувь тийм.

**Ц.Даваасүрэн:** Номинчимэг гишүүн асуултаа асууна.

**О.Номинчимэг:** За би энэ ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуультай холбоотой өчигдөр ч байр сууриа илэрхийлсэн. Тэгээд энэ ийм юм байгаа юмаа, гишүүддээ бас хэлэхэд, бид нар нэг их хувийн өмчийн сургууль цэцэрлэгийг гадуурхаад байгаа юм байхгүй. Хааж боох гээд байгаа юм байхгүй, дэмжихгүй байгаад байгаа ч юм байхгүй. Төрөөс энийг дэмжээд хүүхдүүдэд нь бас хувьсах зардлыг болбол олгодог байгаа тиймээ. Төрийн үнэхээр хийж чадахгүй байгаа одоо манай 30 жилийн л алдаа шүү дээ. Боловсролдоо хөрөнгө оруулахгүй байсны алдааг одоо энэ дээр мэдээж хүүхдүүдтэй хүн боловсролд нь анхаарна. Энэ зах зээл байгаа. Энэ одоо хэрэгцээ шаардлага дээр л хувийн хэвшил орж ирж байгаа. Гэхдээ бид нар цаашдаа энэ хэвээрээ яваад байх юм бол яах вэ гэдэг дүр зураг байгаа.

Ер нь болбол хувийн хэвшлийн сургуулиуд ачаа үүрч байгаа гэж байгаа боловч яг үнэндээ хэлэхэд энэ хувийн хэвшлийн сургуулийн ачаа гэдэг маань жинхэнэ утгаараа болбол аав ээж нь л ачааг нь үүрч байгаа шүү дээ. Аав ээж нь төлбөрийг нь төлөөд, нөгөө нэг баахан цалингаасаа хөдөлмөрлөсөн цалингаасаа ..төлөөд, татвараа төлөөд дээр нь хүүхдүүддээ санаа зовоод гайгүйхэн боловсролтой болгочихъё гээд төлбөрөө төлж байгаа юм. Тэгээд нөгөө бид нар дундаж давхаргаа дэмжье ээ, энээ тэрээ гээд л бодлого байдаг. Тэгтэл яг эсрэгээрээ чи ямар ч сонголтгүй одоо хувийн сургууль руу л хүүхдээ өг, төлбөртэй сургууль руу л хүүхдээ өг, төлбөргүй улсын сайн чанарын сургууль байхгүй болох нь ээ гэдэг бодлого руу цаашдаа яваад байна шүү дээ. Ингээд энэ утгаараа бол энийг бас дэмжиж боломгүй байгаа юмаа.

2 дугаарт ерөөсөө зарчмын хувьд, логикийн хувьд ийм байгаа байхгүй юу. Энэ чинь төсөвт орох ёстой татварын орлого шүү дээ уг нь болбол авах юм болбол, тэгтэл төсвийн мөнгөөр хувийн өмчийн, хувийн хүний өмчийг одоо барихад зарцуулъя аа гээд байгаа байхгүй юу. Тэгээд өмчлөгч нь хувийн хүн байх юм байна л даа. Одоо тэр юу байдаг юм сургууль нь тиймээ. Тэгээд энэ чинь болбол тэр аав ээжийн төлбөрөөс хөнгөлөх асуудал биш шүү дээ. Тэр хувийн одоо өмчийг юу сургуулийг өмчилж байгаа этгээд сайхан өмчтэй 20, 30 жил хэрэглэх өмчтэй болоод сайхан л байх, баялаг нь ихсэх л байх. Тэгтэл тэнд нэг хэдэн жил хүүхдээ сургах гэж байгаа аав ээжийн нуруунаас ачаа нь авагдах юм уу гэвэл үгүй шүү дээ, адилхан л төлбөрөө төлөөд явна шүү дээ.

3 дугаарт одоо ингээд нийслэл дээр яах вэ орон нутагт бол нэлээн их одоо манай орон нутгийн гишүүд чинь төсөв дээрээ янз бүр болохдоо сайн. Баахан л сургууль, цэцэрлэг тэндээ барьчихсан. Дотуур байрны бол асуудал зөндөө байгаа. Нийслэлд ингээд ёстой 40, 50-иулаа баахан шахцалдсан, агааргүй орчинд хүүхдүүд сураад, 3 ээлжээр сураад, хүүхдээ хамран сургах тойрогт нь оруулъя гэхээр

болохгүй байна аа гээд ингээд зөндөө байгаа шүү дээ. Тэгээд тэр Сонгинохайрхан, Чингэлтэйд 2, 3 км алхаж ирээд, уулын дээрээс алхаж ирээд сургуульд очдог хүүхдүүд байгаа шүү дээ. Тэнд хувийн сургуулиуд одоо энийг энэ хуулийг баталснаар сургууль барих юм уу, барихгүй шүү дээ, хэзээ ч тэр хүүхдүүд жилийн 10, 15, 20 сая төгрөг төлөөд хувийн сургуульд сурахгүй шүү дээ. Тэгээд ингээд төр хийх ёстой юмандаа өөрийнхөө нөөц боломж, татварын мөнгөө хязгаарлахгүй яагаад ингээд хүний хувийн өмчид одоо хөрөнгө оруулна аа гээд сууж байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа байхгүй юу. Хэний лобби юм бэ? Жавхлан сайдаас эндээс хариулт авъя.

**Ц.Даваасүрэн:** Уг нь байна шүү дээ үндсэн хуулиараа энэ ерөнхий боловсролын сургалт чинь үнэгүй байх ёстой байхгүй юу. Гэтэл өнөөдөр ингээд хувийн хэвшлийн сургууль гээд ерөнхий боловсролын мэдлэг олгохдоо одоо төлбөр аваад байгаа чинь Үндсэн хууль зөрчөөд байгаа байхгүй юу. Тэгээд Боловсролын яам энэ дээр одоо ингээд таг дуугүй яваад байдаг юм. Би учрыг ерөөсөө олохгүй байна. Энэ чинь Үндсэн хуулийн зөрчилтэй асуудал шүү дээ. За Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад хариулъя. Ямар юмных нь лобби байх вэ дээ. Боловсролын яамнаас гаргасан тооцооллоор ирэх жилээс ингээд боловсролын жил болгон зарлаад нийтдээ нэг 100 цэцэрлэг, 100 ерөнхий боловсролын сургууль буюу нийтдээ нэг 5.6 их наяд төгрөгийн төсөвтэй ийм хөрөнгө оруулалтууд хийж байж хамран сургалтын коэффициент ер нь нэг зорилтот түвшин рүүгээ нэг рүү ойртох юм байна лээ. За энийг бид хийж чадах уу? Алдагдалгүй төсвөөр. За ингээд бид одоо бол одоо уул уурхайгаас хамааралтай, ганц нүүрснээс хамааралтай ийм төсөвтэй улс ингээд хумигдаад ирэхээр энийгээ тэгээд яах вэ, хаанаас хийх вэ? Агаараас хийх үү, хаанаас хийх вэ. За ингээд сургууль цэцэрлэг барих нь нэг хэрэг.

За дараа нь урсгал зардал гэж энэ хөрөнгө оруулалтаасаа илүү зардал байдаг. Энэ дээр хувийн хэвшил орж ирээд, хөрөнгө оруулалт хийгээд өөрсдөө эрсдэлээ хариуцаад, төлбөртэй байна уу, төлбөргүй байна уу, яам нь өөрөө бодлогоо гаргаад энэ дээрээ одоо ийм чиглэлээ гаргаад, энийгээ дэмжээд явъя гэж байгаа дээр одоо энэ хувийн хэвслээс гадна гадаадын хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн түншлэл өөр ямар л боломжит эх үүсвэр байна бүх боломжуудыг нь тавьж өгье гэдэг л ийм л зорилго тавьж байгаа ийм зүйл юм байгаа юм. Тийм учраас энийг одоо манай гишүүд дэмжиж байгаад баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Номинчимэг гишүүн тодруулъя.

**О.Номинчимэг:** Яах вэ тэгээд одоо ийм байгаа шүү дээ. Бид нар чинь яг том зургаар нь харах юм бол ерөөсөө хүмүүстээ уг нь болбол ерөнхий боловсрол чинь үнэгүй байх ёстой гэж байгаа боловч тэр сонголтыг нь өгөхгүй. Одоо яг энэ бодлогоороо болбол та нар хувийн хэвшлийн сургуульд л сур аа, тэнд чинь хамгийн сайн нөөц бололцоо, хамгийн сайн багш нар, хамгийн сайн орчин чинь тэнд байна аа. Тэгэхээр чи хүүхдийнхээ боловсролд анхаардаг бол ерөөсөө сонголт байхгүйгээр төлбөртэй сургуульд яв гэдэг сонголт руу өөрсдөө, зам руу өөрсдөө түлхээд байгаа байхгүй юу. Тэрийг л хэлээд байгаа юм. Тэрнээс хувийн хэвшлийг нэг хавчих гээд, сургуулийг одоо үүргээ гүйцэтгэж байгаа сургуулийг хавчих гээд байгаа юм биш. Бид нар бодлогын хувьд энэ чинь улсын өөрийнх нь үүрэг. Энэнийхээ үүргийнхээ төлөө нөөц бололцоогоо дайчилж тийшээгээ хийх байтал жилийн дундаас ийм нэг...байгаа байхгүй юу.

**Ц.Даваасүрэн:** Тодруулах чинь 1 минут байдаг, яагаад 2 минут өгөөд байна аа.

**О.Номинчимэг:** Энийг энэ хуулийг байна шүү дээ. Улсын болон орон нутгийн өмчит тэр сургууль, цэцэрлэгт энэ ААН-ийн албан татварын хөнгөлөлтийг ашиглана аа гээд ороод ирэх юм бол ерөөсөө 2 гараа өргөөд дэмжинэ. Энэ бол байж болно тиймээ. Хувийн хэвшил мөнгөө гаргаад, боловсрол санаа тавиад, байшин барилга бариад, өргөтгөлийг нь бариад төрд өгнө гэх юм болбол 2 гараа өргөөд дэмжинэ. Баярлалаа. Тэгэхгүй хувийн өмчийн одоо юу гэдэг юм тэр Орчлон сургууль тэнд 3 давхар том өргөтгөлөө барьж байна, өөр янз бүрийн сургуулиуд барьж байна. Одоо тэнд л тэр хүмүүс чинь ашиглана шүү дээ. Одоо жилийн дунд 7 сард энийг баталлаа гээд бүгдээрээ зураг төсөл нь гацсан, газар чөлөөлөлтийнхөө боломжоор хийчихсэн сургуулиуд дээр нэмэлт юм ерөөсөө хийгдэхгүй шүү дээ. Тэгээд энийгээ жоохон засаад зөвхөн төрийн өмчийн болгоод, намар оруулаад ирээч ээ л гээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ 29.9 дээр чинь угаасаа анх энэ татварын хөнгөлөлтийг бол угаасаа нийтийн зориулалттай юманд л зарцуулъя гэж байгаа шүү дээ. Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын болон эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулахаар бол татварын хөнгөлөлт. Тэгсэн чинь одоо бүр барилга байгууламж өмчийн асуудал дээр хувийн өмч ороод ирж байгаа байхгүй юу. Энэ чинь зарчмын хувьд буруу шүү дээ. Энийг ерөөсөө ингээд гуйвуулаад, ингээд яриад байх ямар ч шаардлага байхгүй. Зарчмын юм байхгүй юу.

**Ц.Даваасүрэн:** Энэ манай техникийнхэн яагаад дэг зөрчүүлээд байна аа. Энэ тодруулга чинь нэг минут байдаг байхгүй юу. Тэгэхээр 3 минут энэ тэр өгөөд байх юм. Дэг зөрчөөд байж байж болохгүй шүү дээ. Анхаараарай энэ алдаагаа зас. Санал хэлчихлээ тиймээ, санал хэлчихлээ.

Ер нь болбол манай Боловсролын яамныхан анхаарах хэрэгтэй шүү. Энэ мэдээж одоо яах вэ хувийн хэвшлийнхэн тэр сургууль, цэцэрлэгт хөрөнгө оруулдаг л юм байгаа биз. Гэхдээ төлбөр авч байгаа чинь ялангуяа ерөнхий боловсрол олгоход болбол үндсэн хуулийн зөрчилтэй шүү. Монгол Улсад ерөнхий боловсрол олгоход үнэ төлбөргүй байна аа гээд Үндсэн хуульдаа хийчихсэн байгаа. Уянга гишүүн. Ер нь болбол байна шүү бид нар асуулт тасалсан л бол тэгээд л дэг зөрчигдөнө шүү дээ. Тэгэхдээ энэ удаа асууя гээд байгаа учраас. За Уянга гишүүн асуучихъя.

**Б.Уянга:** Асуулт асуух боломжоор олгож байгаа Даваасүрэн даргад маш их баярлалаа. Өнөөдөр энэ төсвийн тодотголыг дагаж орж ирж байгаа Алт 3 аян дээр сая Батжаргал гишүүн ч хэлж байх шиг байна. Ганхуяг гишүүн ажлын хэсгийн даргын хүрээнд ч гэсэндээ энэ үр өгөөжийг нь ер нь дийлэнхийг нь сумдад үлдээх нь буруу юмаа гэдэг дээр бол саналууд хэлээд зарчмын санал гарч байх шиг байна л даа. Мөнхсоёл гишүүн ч гэсэн хэлж байх шиг байна. Энэ дээр тэгээд заавал тайлбар хэлэх бол хэрэгтэй. Тэгээд мэдээж эрхэм гишүүдийнхээ саналыг бол хүндэтгэж байна аа.

За ер нь бол уул уурхайн салбарын үр өгөөж гэдэгт зөвхөн эдийн засгийн агуулга буюу АМНАТ-ийн хуваарилалт бол ордоггүй юмаа Мөнхсоёл гишүүн ээ. Ецө бас нийгмийн үр өгөөж бол байдаг. Байгаль орчинд бас өгөх үр өгөөж бас байдаг аа. Тэгэхээр энэ гурвынх нь дийлэнх нь хэрвээ тухайн яг төсөл хэрэгжиж байгаа газарт нь үлдэж байвал энэ хариуцлагатай уул уурхай, энэ салбарын дэмжлэг байх ёстой. Тэгээд энийг маш сайн ойлгодог салбарын сайд маань бас татахад асуудалгүй гэж байгаа болбол дараа дараагийн удаа хөндөөд явахад бол асуудал

байхгүй байх аа. За ингээд үндсэн хуулийн зөрчил рүү хүргэж байна аа гээд энэ саналыг маань тэгээд байгаа юм.

За тэгэх юм бол одоо Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлээр АМНАТ-ийн 10 хувийг орон нутгийн нэгдсэн сан руу бол хуваарилдаг юмаа. Тэрний 30 хувь нь орон нутгийн энэ нэгдсэн сандаа одоо уул уурхайтай аймгууд руу дандаа хуваарилагдаад байдаг аа. 70 хувь нь болохоороо бусад байхгүй газрууд руу жигд хуваарилагддаг аа. Энэ үндсэн хуулийн тэгвэл зөрчил биш үү. Тэгээд аймгуудад хуваарилагдчихаад цаашаагаа сумдууд руугаа явдаг аа. Өнөөдөр ДНБ-ий 12.5 хувийг гаргаж байгаа ЭТТ компани байдаг. Өмнөговь аймгийн Цогтцэций сум сургуульгүй байгаа шүү дээ. Сургууль нь нурчихсан. Энэ сумдад өгч байгаа үр өгөөж нь байхгүй юм биш үү Мөнхсоёл гишүүн ээ. Тэгэхээр энийг яг газар дээр нь буулгаад мэдээд байгаа учраас энийг нь одоо хууль эрх зүйн орчноо сайжруулахдаа Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яам нь судлаадхаач ээ гэсэн ийм заалтан дээр оруулсан үгэн дээр л эмзэглээд л ингээд байх юм. Тэгээд одоо мэдээж та бүгдийн маань мэргэн сонголт шийдэгдэх мэдэх байх.

Тэгэхдээ дараа дараагийн удаагийн энэ уул уурхайн үр өгөөжийг зөвхөн АМНАТ гэдгээр нь битгий хараач ээ. Зөвхөн мөнгөөр харсаараа байгаад бүх мэдлээ Сангийн яамныханд өгсөөр байгаад ингээд салбар бол тэр чигтээ хаагдахад хүрч байгаа гэж бол хардаг. Тэгээд энэ дээр бол одоо асуулт асуух нь ч одоо илүүц байх аа. Ямартай ч саяын өгсөн мэдээлэл бол бүгд яг хууль зүйн үндэслэлтэй, тайлбаруудыг нь бас дэлгэрэнгүй бас өгөх боломжтой гэдгийг хэлье ээ. Баярлалаа төсвийн байнгын хорооныхонд.

**Ц.Даваасүрэн:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарим гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналыг ямар тохиолдолд одоо хураах вэ гэвэл Дэгийн тухай хуулийн 42.2.3-аар нэгдсэн хуралдааны одоо анхны хэлэлцүүлгээр олонхын санал авсан боловч эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хорооны хуралдаан дээр гишүүн санал гаргаад, Байнгын хорооны гишүүдийн 3-ны 2 нь дахин санал хураах шаардлагатай гэж үзэх юм бол дахин санал хураалт явуулж болох юм байна.

За ингээд би 2 санал гарсан байна. Тэгээд би та бүгд нэг нэгээр нь хураалгая. За эхний Ганхуяг гишүүн болон Мөнхсоёл уучлаарай, нөгөөдөх нь 3 дахь нь хэн байлаа. Батжаргалаас гадна Батжаргал гишүүн нэмэгдэх билүү? За тэгвэл Ганхуяг, Мөнхсоёл гишүүн, Батжаргал гишүүн нарын гаргасан санал юм байна шүү.

Энэ 3 гишүүний гаргасан санал бол тогтоолын төслийн нэг дэх заалтын 2 дахь дэд заалтын төсөл хэрэгжиж байгаагаас өмнө үр өгөөжийн дийлэнхийг үлдээх гэсэн үндсэн хуулийн зөрчилтэй учраас хасъя гэдэг санал юм байна. За энэ саналыг гишүүд ээ санал хураалтад бэлтгэе, санал хураалтад бэлтгэе. За гишүүдээ санал хураалтад бэлтгээрэй. Дамдинням гишүүн ороогүй байна, Ганзориг ороогүй байна, Ганзориг ороогүй байна бэлэн бус байна, Мэндсайхан гишүүн ороогүй байна, Мэндсайхан гишүүн ээ ороогүй байна, Пүрэвдаваа гишүүн байна уу, Чойжилсүрэн гишүүнийх бас ороогүй байна, дахиад яа. Одоо Чойжилсүрэн гишүүн үлдсэн байна. Чойжилсүрэн дахиад яагаач. За болчихлоо. Ингээд санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, Мөнхсоёл, Батжаргал нарын гаргасан энэ нөгөө төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээх гэснийг хасах гэдэг энэ саналыг хураах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 3-ны 2-оор дэмжигдвэл хураана шүү.

21 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 47.6 хувиар энэ санал дэмжигдсэнгүй ээ. Тэгэхээр санал хураах боломжгүй боллоо.

Үндсэн хуулийн зөрчилтэй 1 тэгэхдээ уг нь энэ чинь одоо ийм хууль гаргаж болохгүй биз дээ. Яах юм. Цэц дээр очвол одоо тэгээд нөгөө бүхлээрээ унасан юм болох вий дээ.

Дараагийн Батжаргал гишүүний санал. Төслийн нэг дэх заалтын 5 дахь дэд заалтад өөрчлөлт оруулах зорилгоор зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах хилийн заагт өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын 2020 оны 40 дүгээр тогтоолын зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүл гэснийг хасах талаар дахин санал хураалт явуулъя гэсэн байна. Болно болно. За тайлбар Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Гишүүд ээ, хэдүүлээ нэг жоохон асуудалдаа нухацтай хандмаар байх юм. Эрх зүйт төр төлөвшүүлж байгаа гээд баахан хууль ярьцгаана. Хууль хоорондын зөрчилтэй, үндэсний эрх ашиг нийт ард түмний эрх ашигт сөрөг нөлөөтэй ийм шийдвэр гаргаад байж таарахгүй. Ажлын хэсэг хэнээсээ захиалга авчихсан юм. Янз бүрийн асуудлууд оруулж ирээд байгаа. Ажлын хэсгийн нэмэлт томъёоллыг л дэмжихээ больё гэж байгаа шүү дээ. Тэрнээс Засгийн газрын өргөн барьсан уг тогтоол дээр байгаа үндсэн санаа нь хадгалагдаад үлдэж байгаа байхгүй юу. Нэмэлт ажлын хэсгийн гаргаж байгаа саналыг одоо дэмжихгүй унагачихаар зэрэг цаад Засгийн газрынх нь тогтоолд орж ирсэн заалт нь хэвээрээ үлдэж байгаа байхгүй юу. Зохицуулалтгүй үлдэж байгаа юм шиг бодоод ингээд асуудалд хандаад байх юм, эс үгүй бол адармаалаад хэргээр тэгээд байдаг юм уу.

Ер нь хэдүүлээ гарч байгаа шийдвэр юмнууд бас энэ нэг эрх мэдлийн хуваарилалт, тэр гүйцэтгэх засаглал хийдэг ажлаа хийж, өөрт олгогдсон эрхийнхээ хүрээнд хууль тогтоох засаглалдаа өргөн барьдаг тэр зарчим марчмаараа явах ёстой. Тэрнээс хууль тогтоох засаглал нь даалгавар өгч, захиалга өгч асуудал шийдүүлдэг ийм юм байж таарахгүй. Ийм үүднээс би тэр тогтоолын 2 дахь заалтын 5 дахь дэд заалтад оруулаад байгаа Ажлын хэсгийн нэмэлт заалтыг 3-ны 2-оор одоо юу яаяа хасъяа гэдэг ийм санал гаргаж байгаа юм. Түрүүний тэр 2 дахь заалтын 2 дахь дэд заалтад ч гэсэн яг тийм зүйл байсан. Тэгэхээр энүүнийгээ нэг анхаараад саналаа өгвөл яасан юм бэ дээ та минь энэ чинь.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүний гаргаад байгаа нөгөө Засгийн газрын оруулж ирсэн саналаар нь үлдээе ээ л гээд байгаа юм байна. Батжаргал гишүүний гаргасан горимын саналыг биш ээ гаргасан саналыг хураах нь зүйтэй гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 3-ны 2-оор дэмжсэн тохиолдолд дахин санал хураалт явна.

21 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 57.1 хувиар 3-ны 2 энэ саналд хүрсэнгүй ээ. Хураах боломжгүй боллоо.

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

**10:13**

**Ц.Даваасүрэн:** 5 дахь асуудал. Ер нь бас тэр Батжаргал гишүүний хэлснийг та нар анхаарах л байсан юм даа тэгээд. Их Хурал оруулж ир л гэсэн гэнэ шүү дээ. Одоо нэг баахан алтны төслүүд орж ирнэ.

5 дахь асуудлаа хэлэлцье.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлд Шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмын дагуу хэлэлцэн баталж болно гэж заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсэг Ганхуяг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг л байгаа шүү дээ тийм биз дээ. За Улсын Их Хурлын ажлын хэсэг шүү.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танилцуулна.

**Х.Ганхуяг:** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын чуулганд хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 4 үе шатаар хэлэлцэж байна аа.

Төсвийн тодотголын төслийн 2 дугаар хэлэлцүүлгийн үед төрийн үйл ажиллагаа үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн зарим салбарын санхүүжилтийг шийдвэрлэх талаар Улсын Их Хурлын гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй санал дэмжигдэн, түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд дулааны 3 дугаар цахилгаан станцад гарсан үйлдвэрийн ослоос үүдсэн засвар шинэчлэлийн ажилд зориулсан санхүүжилтэд туссан зардлыг Улсын Их Хурал зайлшгүй шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

Төсвийн тухай хуулиар тухайн жил батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжих дүнг тодотголоор бууруулж болох уу гэж заасан байдаг. Улсын Их Хурлын зарим гишүүдээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжих дүнг бууруулах энэ хуулийн заалттай нийцүүлэн санал гаргасныг санал хураах боломжгүй гэж үзсэн болно. Харин 2025 оны төсвийн жилд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй хэвийн

үргэлжлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгийн зардлыг шийдвэрлэх нь зүйтэй байна аа.

Иймээс улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх дээрх төсөл арга хэмжээнүүдийг нь төрийн худал авах үйл ажиллагаа шуурхай зохион байгуулах ажиллах шаардлагатай байна аа. Түүнчлэн төрийн албан хаагч нар хүнийг эрхэлсэн ажил албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй гэсэн Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх ёстой гэж үзэн төрийн албан хаагчийн цалин хөлс, тусламж тэтгэмжийг бүх салбарт тэгш шударгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар зохион байгуулахыг Засгийн газарт даалгах нь зүйтэй байна аа.

Тогтоолын төслийн нэг дэх заалтад Засгийн газарт үүрэг болгосон зохицуулалтыг, 2 дахь заалтад тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах асуудлыг тус тус тусгалаа. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Ганхуяг гишүүнд баярлалаа. Байна уу? Тогтоолын төслийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Одоо санал хураалт явуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. За санал хураалтад бэлтгэе. Эхлээд бэлтгэе, болсон уу? Энэ чинь нөгөө бэлтгэдэг болчихсон учраас их төвөгтэй. За болоогүй байна даа. Аубакир гишүүнийх болоогүй байна, Батбаяр гишүүнийх болоогүй байна, Батболд гишүүнийх болоогүй байна, Чойжилсүрэн гишүүнийх бас болохгүй байна. Заяабал гишүүн бас болохгүй байх юм. Мөнхсоёл. Санал хураалтад бэлтгэе. Мэндсайхан гишүүн, Чойжилсүрэн гишүүн болчихсон байна, Ганзориг гишүүн бусад нь байна уу, байхгүй байна уу.

За Пүрэвдаваа гишүүнийх болохгүй байна. Мэндсайхан гишүүнийх бас л болохгүй л байна даа Мэндсайхаан. Орохгүй байна аа. За одоо болчихлоо. Ганзориг гишүүн байхгүй байгаа юм уу? Баясгалан байна. За одоо санал хураалт явуулна гишүүд ээ.

Ажлын хэсгээс гаргасан тогтоолын төслийг хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн дарга Ганхуяг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдах ёстой холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

**10:19**

**Ц.Даваасүрэн:** Дараагийн асуудал. Дараагийн асуудлыг хэлэлцэхэд хүндэтгэх шалтгаангүй бүх гишүүд оролцсон байх хуулийн заалттай. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр. Тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулах холбогдолтой асуудлыг болбол одоо бүх гишүүд оролцож шийдвэрлэнэ ээ гэсэн ийм заалттай учраас гишүүд хуралдааны танхимд орж ирнэ үү. Байнгын хорооны гишүүд.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Н.Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Дэлгэрмаа Эдийн засаг хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга гэсэн ийм ажлын хэсэг байна. Сангийн сайд өөрөө оролцдоггүй юм уу.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд Учрал танилцуулна. Учрал сайдын микрофоныг өгье.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төсөлд нэгдсэн төсвийн 2025 оны тэнцвэржүүлсэн орлогыг 3 аравны 3 их наядаар, нийт зарлагыг 1.9 их наяд төгрөгөөр тус тус бууруулахаар тусгасан.

Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахтай уялдан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026-2027 оны төсвийн төсөөлөл өөрчлөгдөх улмаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн хуульд холбогдох өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна аа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг 2025 оны 4 дүгээр сард боловсруулах үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд нүүрсний үнийг 2025 онд 85 ам.доллар, 2026 онд 88 ам.доллар, 2027 онд 92 ам.доллар, 2028 онд 96 ам.доллар байхаар таамаглал ирүүлсэн.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн макро эдийн засгийн үзүүлэлтийн тооцоо төсөөллийг боловсруулахдаа тухайн үеийн олон улсын зах зээлийн нөхцөл байдал, мэргэжлийн шинжээчдийн зарласан үнийн төсөөлөл зэргийг харгалзан нүүрсний үнийн төсөөллийг тус зөвлөлөөс ирүүлсэн төсөөллөөс бууруулж, 2025, 2026 онд 80 ам.доллар, 2027, 2028 онд 77 ам.доллар байхаар тус тус тооцсон. Гэсэн хэдий ч 2025 оны 4 дүгээр сард сэргэж эхэлсэн байсан уул уурхайн биржийн арилжааны идэвхжил 5 болон 6 дугаар саруудад эргэн саарч, нүүрсний үнэ үргэлжлэн буурч, 2025 оны эхний 5 сарын байдлаар дундаж үнэ 72 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 39 хувиар буурахын зэрэгцээ эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувь болж саараад байна.

Цаашид дунд хугацаанд төсвийн орлого бидний төсөөлснөөс бага байх эрсдэл өндөр байна аа. Тухайлбал ОУВС нүүрсний үнийг 2025 онд 68 ам.доллар, 2026 онд 73 ам.доллар, 2027-2028 онд 72 ам.доллар орчимд байх төсөөллийг зарлаад байна аа. Энэ хүрээнд макро эдийн засгийн болон төсөв, төсвийн төлөв байдал, цаашдын чиг хандлага, төсөөлөлд үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн ч тус хуульд 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойш өөрчлөлт орсон тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан хязгаарлалтаас шалтгаалан Төсвийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар жилийн төсвийн төслийг 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх боломжгүй болох нөхцөл үүслээ.

Иймд макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд үндэслэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг бууруулах өөрчлөлтөд орсонтой холбогдуулан жилийн төсөв болон төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлахад Төсвийн тогтвортой байдлын хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.5 дахь хэсэгт заасан хязгаарлалт хамаарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж та бүхэнд танилцуулж байна аа.

Сүүлийн 10 жилд зөвхөн нэг удаа буюу 2015 онд экспортын түүхий эдүүдийн үнэ уналттай байсан жилд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээг нэгэн зэрэг бууруулах байдлаар төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж байсан бол бусад жилүүдэд нь орлого зардлыг нэмэгдүүлэх өөрчлөлт хийж байсан гэдгийг энд тодотгон хэлье ээ.

Уг хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын хуулийн 7 дугаар зүйлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын доод дээд хэмжээг бууруулах өөрчлөлт орсонтой холбоотойгоор жилийн төсөв болон төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарт хамаарахгүй байх агуулгатай заалтыг нэмэхээр тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар жилийн төсөв болон төсвийн тодотголыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нөхцөл бүрдэх юмаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Жавхлан биш ээ юу Учрал сайдад баярлалаа. Жавхлан сайдыг оролцуулъя. Энэ бас хариулт өгөх шаардлагатай шүү. Тогтвортой байдлын хууль хэлэлцэж байгаа юм чинь.

Хуулийн төсөл, танилцуулгатай холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Ганбаатар гишүүн ээ та байх хэрэгтэй юм байна шүү. Одоо энэ хуулийн төслийн санал хураалт явуулахад байна шүү дээ. Батбаяр гишүүн, Батболд гишүүн, Баясгалан гишүүн, Батболд гишүүн ороод, Баясгалан гишүүн, Болормаа

гишүүн ороод ирсэн байна тиймээ. Ганзориг гишүүн ороод ирсэн байна. Пүрэвдаваа гишүүнийг дуудах хэрэгтэй юм байна шүү. Эдгээр гишүүд байх шаардлагатай. Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тодорхой үндэслэл нөхцөлөөр өөрчлөлт оруулах шаардлага үүслээ гээд хуулийн төсөл оруулж ирж байгаа юм. Энэ төсвийг дунд хугацаанд нь зөв төлөвлөх, төсвийн сахилга хариуцлагыг чангатгах үүднээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өмнөх бүрэн эрхийн хугацаанд өөрчлөлт оруулж тодорхой бас тийм хязгаарлалтууд хийж өгсөн юм. За тэр нь өнөөдрийн энэ дэлхийн улс орнуудын улс төр, эдийн засгийн нөлөөллөө хадгалах, дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжих замаар дэлхийн эдийн засагт өөрийн эзлэх хүрээг тэлэх гэсэн энэ нэг бодлогын үйл явдлаас хамаараад тарифын хязгаарлалтууд янз бүр тогтоогдоод энэ нь эдийн засгийн нийт эргэлтэд нөлөө үзүүлээд, тэрнээс хамаараад манай нэг салбар дээр тулгуурласан эдийн засгийн маань тэр тусмаа нэг эрдэс дээр тулгуурлагдсан эдийн засаг төсвийн маань асуудалд тодорхой сүүдэр асарч байна аа.

Тийм учраас бид төсвөө дунд хугацаанд нь тогтвортой харж, түүнийгээ барих ёстой гэж муйхарлаад суугаад байж боломгүй болчихлоо л доо. Энэ улсуудыг нэг бол төсвөө 9 сарын 1-нд өргөн барих боломжгүй болгочих гээд, нэг бол худлаа хязгаарлалтад багтаж төсвөө боловсруулж оруулж ирэх ийм нөхцөлийг үүсгэх гээд байгаа учраас энэ одоо өөрчлөлтийг бид хийхээс аргагүй. Гэхдээ орж ирсэн төслийг уншиж үзлээ. Ер нь цаашид энэ заалтыг бариад өөрчилдөг арга барил руу явчхаж мэдэхээр. Өчигдөр чуулганы хуралдаан дээр зарим гишүүд Төсвийн тогтвортой байдлын хууль гэх юм уу, тогтворгүй байдлын хууль гэх юм уу гэж ёгтолж байгаа ёгтлолыг ер нь ч бас бодох л ёстой үг юм байна гэж бодоод байгаа юм.

Тийм учраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд орлогын доод хязгаар, зарлагын дээд хэмжээнд бууралт үүссэн бол гэдэг байдлаар өөрчлөлт хийж болохоор орж ирж байгаа заалтыг тодорхой давтагдашгүй гэдэг юм уу, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал үүсчихсэн гэж тийм хэмжээс мэмжээстэй болгож энүүнийг янзлахгүй бол ер нь тэгээд дуртай нь янз бүрийн таамаглал гаргаад, асуудал барьж орж ирээд, үймүүлээд байх магадлалыг энэ цонх нээчих гээд байна аа энэ заалт бас. Тэгэхээр энэ дээр төсөл өргөн баригч ямар бодол санаа байна вэ? Яах аргагүй өөрт орохыг нь бол дэмжмээр байна. Тэгэхдээ цонх нээгээд өгчихөмгүй байна. Хэмжиж чаддаг тэр хэмжээст нөхцөл нь үүс...

**Ц.Даваасүрэн:** Энэний саяхан байна шүү дээ өмнө нь Тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулаад нөгөө Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсон бол одоо хамаарахгүй гэсэн. Тэрэн шиг зүгээр л төсвийн өргөн мэдүүлэгт хамаарахгүй гээд л ганц ийм заалт оруулаад явчихад яагаад болохгүй байна. Тэгээд бүүр байнгын төсвөө өргөхдөө төсвийн хүрээний мэдэгдлээр өөрчилж орж ирдэг ийм заалт байвал энэ чинь дэмжигдэхгүй шүү дээ. За Учрал сайд.

**Н.Учрал:** Тийм, Батжаргал гишүүний саналыг би дэмжиж байна аа. Энэ төсвийн тогтвортой байдлын хууль бол төсвийн сахилга бат хариуцлагыг нэмэгдүүлэхэд маш том дэвшил авчирсан ийм хууль. Тийм ч учраас миний хувьд бол ирэх оны төсвийн хүрээний мэдэгдлийг бас энэ Эдийн засаг, хөгжлийн сайдын хувиар барина. Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг болбол хатуу чанд барьж энэ хуулийн хэрэгжилтийг хангуулахад л би одоо онцгойлон анхаарах ёстой гэдгээ бол бүрэн дүүрэн ойлгож байгаа.

Тийм ч учраас энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг чанд мөрдөхийн тулд одоо зөв төлөвлөх хэрэгтэй. Гэхдээ яг ийм нэг цаг хугацааны болон ийм хуулийн хайчинд орчихлоо л доо. Яг өнөөдрийн нөхцөл байдал бол. 5 дугаар сарын 30-ны өдөр 2026 оны төсвийн хүрээг Их Хурлаар баталсан. Тэр төсвийн хүрээ болбол орлого, зарлага 33 их наядаар төлөвлөөд, эдийн засгийн өсөлт 6 хувьтай байх нүүрсний үнийг 80 доллароор бодсон. Тухайн үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 88 доллар өгөхөд нь 80 доллароор бодоод ингээд оруулж ирсэн юм байна лээ. Гэтэл нүүрсний үнэ өдөр ирэх тусам өөрчлөгдөж байна. Өдөр ирэх тусам. 13-30 хувь буурна аа гээд 14 байгууллага тэр Блүүмбергийн терминал дээр байдаг байгууллагууд нь ингээд төсөөлөөд тооцчихсон.

Тэгээд манайх одоо энэ уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай ийм эдийн засагтай улс байгаад байдаг. Тэгээд одоо нэг тийм 9 дүгээр сарын 1-нд 80 доллароор нүүрсээ зарна аа, 33 их наядын орлого олно оо гээд ийм худлаа ийм төсөв төлөвлөж орж ирээд дахиад л тодотгол руу явах нөхцөл бол үүсчих эрсдэлтэй. Тийм учраас зөв төлөвлөх хэрэгтэй гэдэг утгаараа. Гэтэл өнөөдрийн Төсвийн тогтвортой байдлын хууль дээр ямар асуудал байна вэ гэхээр нөгөө дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөлт баталснаас хойш 3-аас доошгүй сарын хугацаанд тухайн жилийн төсвийн төслийг тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно гээд заачихсан.

Тэгэхээр энэ яаж байна вэ гэхээр сая нөгөө Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулаад төсвийн хүрээ өөрчлөгдөөд одоо ингээд батлагдах гэж батлагдчихсан. Төсвийн тодотгол ингээд батлагдчихаар 7 дугаар сарын одоо 6, 7-ноос хойш ингээд тооцвол 10 дугаар сарын 5 хүртэл Засгийн газар төсөв өргөн мэдүүлж болохгүй хуультай. Яагаад гэвэл төсвийн хүрээ чинь өөрчлөгдчихсөн. Тэгээд ийм нэг юм байгаад байгаа юм. Тийм учраас Батжаргал гишүүний яг хэлсний дагуу нөгөө орлого, зарлага нь аль аль нь буурч байгаа тохиолдолд 2015 онд л нэг ийм кэйс байсан байна.

Тэгэхээр орлого, зарлага нь аль аль нь буурч байгаа тохиолдолд бол энэ 7.5 гэсэн 3 сарыг хамаарахгүй болохоос биш орлого нэмэгдүүлж байгаа юм. Зарлагаа өсгөж байгаа тохиолдолд болбол ерөөсөө ийм байдал төсвийн тогтвортой байдлын хуулийг энэ хамаарахгүй гэж явж ерөөсөө болохгүй. Нэг ёсондоо нүүрсний үнэ унадаг, бүтээгдэхүүний үнэ унадаг, ингээд орлого, зарлага нь аль аль нь буурч байгаа тохиолдолд. Тэгэхээр томьёолол дээрээ гишүүд маань одоо орлого, зарлага нь аль аль нь буурч байгаа бол ч гэдэг юм уу, таны хэлж байгаагаар тэр урьдчилсан тооцох бололцоогүй ч гэдэг юм уу ийм хатуу ийм хэмжүүр болбол тавьж өгөх нь зөв гэж үзэж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ч ...

**Ц.Даваасүрэн:** Яах вэ гишүүд болохоор нөгөө тэгээд байнга тодотгодог болчих вий л гэдэг санаа зовоод байгаа юм. Тэгэхдээ та хэд бол зөвхөн зарлага, орлого буурч байгаа тохиолдол гээд байна л даа. За Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Тогтвортой байдлын хуульд сарын дотор 2 дахь удаагаа өөрчлөлт оруулж орж ирж байна. Тэгээд би энэ сүүлийн энэ өөрчлөлтийн асуудал бол өөрөө их тусгай дэг зохицуулалттай, журамтай асуудлууд байгаад байгаа юм. Тэгээд би энэ дээр нэг зүгээр асуух гээд байгаа зүйл бол үндсэндээ бид нар энэ хуульд өөрчлөлт оруулахгүй байх үүднээс, хуулийн энэ дүрэм журмуудыг мөрддөг

байх үүднээс, хуулийн хэрэгжилтийг хангадаг байх үүднээс төсвийнхөө хүрээ буюу бодлогодоо нийцүүлж төсвөө төлөвлөдөг байлгах үүднээс хуульд өөрчлөлт оруулах босго шалгуурыг нь бол өндөр болгосон юм. Тэгээд энэ өөрөө юу юм гэхээр сая Төсвийн байнгын хорооны дарга ч гэсэн нөгөө групп дээр биччихсэн байгаагаар болбол мэдээлэл өгч байгаа. Яг үндсэндээ ирц бүрэн бүрдэж байж энэ асуудлыг хэлэлцэж эхэлнэ ээ гэдэг асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр би өнөөдрийн хурал дээр болбол үндсэндээ манай Төсвийн байнгын хороо 25 гишүүнтэй, 22 гишүүнээр болбол одоо ирц бүрдээд хуралдаад ингээд явж байна. Тэгэхээр үндсэн 3 гишүүн яг ямар учир шалтгаантайгаар хуралд оролцоогүй байгаа юм бэ? Энд болбол бид нар хууль дээр зааж өгснөөр нөгөө өвчтэй, чөлөөтэй, гадаад дотоодод томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд болбол бусад гишүүд энд ирж оролцоно гэж байгаа юм. Тэгэхээр нөгөө 3 гишүүн маань болбол яг өвчтэй, чөлөөтэй, гадаад дотоодод байгаа гишүүд байна уу гэж байгаа юм. Ийм зохицуулалт хуулийн босго чагт түгжээ хязгаарыг хийхээс өөр аргагүй байх байсан юм. Яагаад вэ гэхээр хуучин болбол 2015 он хүртэл болбол 4-ний 3-аар өндөр босгоор энэ хуульд өөрчлөлт оруулъя гэж шийдэгддэг байсан юм. Бараг үндсэн хуулийн өөрчлөлтийн хэмжээнд. Тэрийг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр 2015 онд байхгүй болгочихсон юм.

Тэгээд үндсэндээ хуулийн ийм хязгаарлалт байхгүй болчхонгуут одоо үндсэндээ болбол ирцээрээ одоо бид нар хязгаарлалт хийж, босгыг нь өндөр болгох, хуулийг одоо байн байн өөрчлөөд байхыг нь хориглохоос өөр аргагүй болчхоод байгаа юм. Тэгэхгүй бол өөрөө яаж байсан гэхээр гишүүд бүгдээрээ л мэдэж байгаа. Энэ 10 хэдэн жилийн хугацаанд 20, 30 удаа л өөрчлөлт оруулж байсан, жилдээ 2, 3 оруулдаг ч гэдэг юм уу. Энийг л хязгаарлах гэж хийж байгаа зохицуулалт байгаад байгаа юм. Тэгэхээр би 1 дүгээрт энэ хуулийг хэлэлцэж эхлэх одоо нөхцөл нь бүрдсэн юм уу. Энэ 3 гишүүн яг ямар учир шалтгаантай байна вэ гэдэг асуудлыг би 1 дүгээрт тодруулах гээд байгаа юм. Чуулган дээр ч энэ явах ёстой, Байнгын хороон дээр чуулган дээр ингэж хатуу өндөр босготойгоор бид нар энэ хуулийг өөрчлөлт оруулах хязгаарыг болбол дээшлүүлж өгч байгаа юмаа. Энэ болбол Монгол Улсын төсөв, санхүү, эдийн засагт өөрөө онцгой ач холбогдолтой хууль учраас бид нар энэ тогтвортой байдлыг нь барих, хуулиа мөрддөг байх энэ зохицуулалтыг хийж өгөөд байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Булгантуяа гишүүн орчхоод орж ирээд гараад явсан. Булгантуяа гишүүн заавал оролцох ёстой. Булгантуяа гишүүн байгаа байхгүй юу. Сая энд сууж байгаад гараад явчихсан шүү дээ тийм. Булгантуяа гишүүн оролцож байгаа би яг энэ асуудал дээр орно гээд. Хэн нэг нь өвчтэй, Алтанхуяг өвчтэй, Ганбаатар гишүүн чөлөөтэй гэсэн ийм 2 юм байгаа юм. Булгантуяа гишүүнийг оруул оруул. Булгантуяа гишүүн сая түрүүн сууж байгаад гараад явсан шүү. За Учрал гишүүн хариулъя. Санал хураалтад Булгантуяа гишүүн заавал орох.

**Н.Учрал:** Энэ Тэмүүлэн гишүүний санаачилсан Төсвийн тогтвортой байдлын хууль бол өнгөрсөн парламент батлагдсан. Энэ бол үнэхээр төсвийн сахилга бат, хариуцлагыг нэмэгдүүлэхэд маш том реформын шинжтэй хууль байсан гэдгийг өнөөдөр бид мэдрээд энд хэлэлцэж байгаа юм. Тэгэхээр юу вэ гэхээр ер нь энэ төсвийн бодлого гэдэг бол бидний ойлгож байгаагаар бол. Эдийн засаг агшиж байгаа болбол тэлэх бодлого буюу тэр мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх ёстой, ёстой. Мэдээж одоо нөгөө өсөж байгаа болбол энэ бол нөгөө үүргээ сайн биелүүлэх заалт мөн. Харин буурч байгаа тохиолдолд яах вэ гэж. Орлого нь ч буураад байдаг, зарлага нь ч буураад байдаг. Энэ тохиолдолд бид нар зайлшгүй тэр нэг мөчлөг

сөрсөн бодлого хэрэгжүүлж явахгүй болбол болохооргүй болчхоод байгаа учраас энд болбол нэг ийм 3 сарын асуудал үүсээд байгаа юм билээ. Та бас сайн ойлгооч ээ л гэж би хүсээд байгаа юм.

Тэгэхээр одоо юу вэ гэхээр нөгөө 9 дүгээр сарын 1-нд жишээ нь энэ Төсвийн тогтвортой байдлын хуулиар Эдийн засгийн хөгжлийн яам төсвөө төлөвлөдөг, төсвийн хүрээний мэдэгдлээ барьдаг. Тэгээд түүн дээр нь Сангийн яам төсөв хийдэг. Ийм бие биеэ хянах ийм зөв механизм руу оруулсан. Энэ бол маш том дэвшил. Тэгэхээр 9 дүгээр сарын 1-нд би жишээ нь алдагдалгүй төсөв барьж орж ирэхээсээ бол одоо нэрэлхэж байна л даа. Олох боломжгүй орлого тавьчихсан. Тэгээд ашигтай төсөв барьж орж ирээд, тэгээд нүүрснийх нь үнэ дэлхийн зах зээл дээр бараг 70-аас доош буучихсан. Тэгэнгүүт 80-аар тооцсон юмаа би. Тэгээд олохгүй орлого дээр нь зарлага тавьчихаад орж ирэхээр энэ угаасаа нэг барьж орж ирэхэд ч хүндрэлтэй.

Гэтэл нөгөө 3 сараа барья гэхээр бид нар хамтдаа өнөөдөр төсвийн хүрээ баталчихаар өнөөдөр чинь 7 сар гарчихлаа. Нөгөө хугацаа тоолохоор 10 сар хүрчхээд байдаг. 9 сарын 1-нээс өмнө барьчихаар хуулиа зөрчихөөд байдаг, төсвийн хүрээгээ өөрчилчихье гэхээр хуулиа давж чаддаггүй. Тэгэхээр 1 ийм нэг цаг хугацааны нэг ийм асуудал байгаа байгаа учраас л яг энэ заалт бол магадгүй одоо нэг удаа ийм хэрэглэх ч гэдэг юм уу, эсвэл ийм хатуу шаардлага ч тавих юм уу нэг ингээд нэг зохицуулалтыг нь хийгээд өгвөл 9 дүгээр сарын 1-нд үнэндээ ойрхон төсвөө төлөвлөе өө. Үнэнтэй ойрхон.

Дээрээс нь яг ийм төсвийн бодлого дээрээ үнэхээр одоо эдийн засаг ингээд агшиж байгаа болбол тэлэх бодлого барья аа гэвэл тодорхой алдагдал үүсгэж байж бид нар эрэлтийг бий болгоно. Эрэлтийг бий болгохгүйгээр зүгээр ингээд л хоосон хэмнээд л эдийн засаг сэргэнэ гэж юм байхгүй шүү дээ. Эдийн засаг сэргэнэ гэж. Тэгэхээр яг энэ дээр зүгээр 3 гишүүний асуудал гэдэг дээр бол хуулийг харахаар төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, хэрэгжих нөхцөл хугацаанд өөрчлөлт оруулах тохиолдол буюу нөгөө тусгай шаардлага өөрчлөлт оруулахтай холбогдуулаад нөгөө бүх гишүүд гэдэг нөгөө шаардлага болбол байгаа юм байна гэж хуулийг нь харсан. Тэгэхээр тусгай шаардлагыг бол энд бид нар хөндөөгүй.

**Ц.Даваасүрэн:** Чуулганы хуралдаанд юм байна лээ Тэмүүлэн гишүүн ээ. Байнгын хорооны хуралдаанд бол хамаарахгүй юм байна лээ. Тэгэхдээ би оролцуулна. Одоо Булгантуяа гишүүнийг бас оруул. Тэмүүлэн гишүүн тодруулъя. Чуулганы хуралдаанд болбол энэ заалт шууд одоо хуулийн заалттай шүү хамаарна. Тэмүүлэн гишүүний микрофон.

**Г.Тэмүүлэн:** Учрал сайд аа, 5 сарын 30-нд буюу одоогоос дөнгөж сарын өмнө та бүхэн төсвийн хүрээгээ өөрсдөө оруулж ирж батлуулсан шүү дээ Засгийн газар. Одоо тэгээд бид нар энэ бид нарын төсөөлсөн сарын өмнө бодсон нүүрсний үнэ, эдийн засгийн тооцоолол, макро эдийн засгийн энэ төсөөлөл өөрөө буруу байжээ гэж ярьдаг чинь утгагүй байхгүй юу. Бид нар хэлээд байгаа зүйл бол битгий Засгийн газар харалган байгаач ээ. Эдийн засгийнхаа бодлого дээр та нар бодлоготой байгаач ээ. Битгий ингэж гэгээлгээр өөдрөгөөр тооцдог, худлаа тооцдог асуудлаа болиоч ээ л гэдэг асуудлыг тавиад байгаа юм.

Энэ төсөв гэдэг чинь өөрөө юу юм бэ гэхээр орлогын доод хязгаар байхгүй юу. Орлогын доод хязгаар, зарлагын дээд хязгаар байхгүй юу. Тэгэхэд манайхан дандаа 60-80-ын хооронд тооцох ёстой юмыг дандаа хамгийн дээд хязгаараар нь

тооцож авчхаад тэрэндээ дүйцүүлж зарлагаа тооцдог асуудал байгаа байхгүй юу. Хамгийн өндрөөр тооцдог. Энэ чинь урвуу хамааралтай байгаа асуудлыг л залруулах гэж бид нар чинь энэ хуулийг хийгээд байгаа шүү дээ. Тэгээд дандаа одоо цаашдаа зөв бодож хийе гэдэг асуудлыг яриад байгаа юм. Зөв тооцоолж байя, дээд, доод хязгаараа харчихъя гэдэг асуудлыг яриад байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** За хариулъя Учрал гишүүн.

**Н.Учрал:** Яах вэ ер нь 5 дугаар сарын 30-нд Төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн үед одоо Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулж, төлөвлөж оруулж ирсэн байна. Тэгээд би харсан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь тэр нүүрснийхээ үнийг нэг 88 гээд явуулангуут харьцуулж байгаад дундаж үнэ 80 гээд л оруулаад ирчихсэн юм байна лээ. Яах вэ 5 дугаар сарын 30 дээрээ төсвөө төлөвлөөд 9 сарын 1-нд яг хуулийн хугацаандаа барьж болно. Гэтэл бас асуудал үүсэж байна юу вэ гэхээр сая нөгөө Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн гамшгийн үед энэ заалт хамаарахгүй гэсний дагуу төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн тодотгол хоёрыг бид батлах гэж байна шүү дээ одоо. Энэ баталсан хугацаанаас хойш 3 сар тоолох болчихоод байгаа байхгүй юу.

Яагаад гэхээр хуульдаа тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл тодотголыг баталснаас хойш 3 сарын хугацаа гээд заачихаар 5 сарын 30-наа ч барьж чадахгүй болчихоод байгаа байхгүй юу. Тухайн жилд төсвийн хүрээ шинээр ороод ирчихсэн бол дахиад 3 сар тоолчихоор 7 сарын одоо 4, 5 гээд батлагдлаа гэж бодоход бид нар энэнээс хойш 3 сар гэхээр бас хууль зөрчих гээд ийм л юм үүсчхээд байна л даа.

**Ц.Даваасүрэн:** Энэ чинь бас би буруу тайлбар өгсөн байна. Юу хар аа, чуулганы хуралдаан гээд юу хэлэх аль хуралдааныг хэлэх вэ гээд Улсын Их Хурлын тухай хуулийн 15.2 дээр чуулганы хуралдаан гэдэгт нэгдсэн хуралдаан, Байнгын хороо, дэд хороо, Хянан шалгах түр хороо, түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаан, ажлын хэсгээс бусад нь бүгд орох юм байна. Тийм учраас Булгантуяа гишүүн заавал оролцох юм байна шүү. За Булгантуяа гишүүнийг дууд. Мөн байна, мөн байна. Чуулганы хуралдаан гэдэг чинь би зөвхөн нөгөө нэгдсэн чуулганы гэж ойлгоод байсан чинь үгүй юм байна. Байнгын хороо, түр хороо, нам, эвслийн бүлэг тийм тусгай шаардлага өөрчлөх тийм. Булгантуяа гишүүнийг дуудаадах.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? кнопоо дараарай. Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Батжаргал, Баясгалан гишүүнээр тасаллаа. Тэмүүлэн гишүүн яах юм үг хэлэх юм уу болчихсон уу. Баясгалан гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн үг хэлье.

**Ж.Батжаргал:** Би нэг их олон юм яримгүй байна. Гишүүд үүссэн нөхцөл байдлаа хараад, эрх зүйн хайчинд оруулаад, улс орны ирэх жилийн төсвийг одоо бодит нөхцөлөөс нь зөрүүлсэн боолт хийлгэхгүй, эс үгүй бол цаг хугацаандаа өргөн барьж чадахгүй болгочихгүй байх үүднээс энэ хуулийн өөрчлөлтийг одоо хэдүүлээ хийхээс аргагүй ээ. Тийм учраас би дэмжих хэлэлцэхийг нь дэмжье.

Харин анхны хэлэлцүүлэг дээр энэ орж ирчхээд байгаа заалтыг бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Байнгын хорооныхоо гишүүд эд нартай тал бүрээсээ санал солилцож байгаад ер нь бараг тодорхой давагдашгүй хүчин зүйлийн улмаас л ашиглаж болдог тийм заалттай хязгаарлалт болгож өгөхгүй бол энэ болохгүй. Тийм учраас энэ талаас нь одоо хэдүүлээ анхны хэлэлцүүлэг дээр нь сайжруулъя

аа. Тэгээд одоо үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжээд, хэлэлцэх эсэхийг нь дэмжихээс өөр арга байхгүй ээ. Энэ чинь улс орны амьдрал, иргэдийн маань аж, амьдралын асуудал байгаад байгаа учраас.

**Ц.Даваасүрэн:** Мөнхсоёл гишүүн үг хэлье.

**Б.Мөнхсоёл:** Баярлалаа. Энэ төсвийн тодотголтой холбоотойгоор чухал чухал хууль, эрх зүйн одоо өөрчлөлт нэмэлт, өөрчлөлтүүд оруулахаар орж ирж байгаа. Энэ Байнгын хороог бас харж байгаа. Иргэд мэдээлэл авах эрхтэй гэж бодож байна. Түрүүн Уянгаа гишүүн миний нэрийг дурдсаар байгаад гарлаа. Бид 2 вайбераар холбогдож байна. Хариу хэлэх боломжгүй улс төр хийхгүй ээ. Гол асуудлыг ойлгохгүй мушгидаг Дамдинням сайд байна, зарим гишүүд байна саяны мэтийн.

Тэгэхээр гол хэлж байгаа санаа бол алдагдал төсөв яагаад тодотгож байгаа юм. Асуудал байна, мөнгө хэрэгтэй байна, ажил явах хэрэгтэй байна, ажил явуулахдаа улсын ажлыг нуулахдаа хэрхэн яаж, хэзээ тодорхой, хязгаартай төсөв байгааг бид нар бүгд мэддэг, тэрийгээ яаж, ямар хөрөнгө оруулалтыг нь яаж урсгал зардлаа яаж гэж төсөвлөөд баталсан 8 удаагийн хэлэлцүүлгээр. Гэтэл бодит байдал дээр нүүрсний үнэ уналаа тооцсон хэмжээгээр экспортолж чадсангүй, тодотгож байна, аргаа барж байна. Аргаа бараад явуулах ёстой үндсэн ажлуудаа явуулахдаа заримыг нь хуумгай хандаад буруу төсвийг хасаад, буруу төсөв нэмэх, тэгээд хоорондоо улс төр хийгээд ярилцалгүйгээр санал унагах, босгох ийм асуудал зөндөө л байна шүү дээ. Энийг чинь л ярьж байна шүү дээ.

За одоо 2 дугаарт нь Алт 3 энэ төсвийн тодотголтой орж ирсэн. Алт 3-ыг яагаад би энэ далимд нь хэлж байна гэхээр орлого нэмэгдүүлье гэж байна, ойлгож байна. Орлого нэмэгдүүлэхдээ өр авлагаа аваач ээ гэж нэг санал хэлсэн. Хувьчлалаа олон жил явуулаагүй юмнуудаа хийгээч ээ тэр төсвийн төрийн өмчит компаниуд чинь ямар олон жил алдагдалтай ажилладаг юм, тэр хэдхэн хүн ямар өндөр цалинтай ажилладаг юм. Энэ дээрээ анхаараач ээ гэсэн, өөр аргууд руу орооч ээ. Алтаа ух, ухахдаа ухаалгаар ухаа, хариуцлагатай уур уурхайгаа сахь аа, бүгд эзэнтэй байх ёстой хэдхэн хүн шийдэхгүй ээ. Энэ болгоныг л хөндөж байна шүү дээ. Сайн засаглал Монголд байхгүй. Тэр учраас Засаглалын асуудал дандаа хөндөгддөг.

Одоо дахиад төсвийн тодотголтой холбогдуулаад тогтвортой, төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хариу одоо гол хэрэгжүүлдэг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль яригдаж байна аа. Одоо 20 дахь удаагаа өөрчлөгдөж байна, өөрчлөгдөж байна. 19, 20 дахь удаагаа. Булгантуяа гишүүн маань дэд дарга маань ороо ирлээ. Бид хэд төсөв ба цаглавар ажлын хэсгийн хэсэгт одоо хэдэн сар ч ажиллав. Яг энэ заалттай холбоотойгоор бид нар санал зөрсөн байхгүй юу. Тэгээд энийг оруулаагүй. Гэтэл одоо орж ирж байгаа. За энэ яг тодотгол хийх гэж байгаа яалт ч үгүй 3 сарын тэр хугацаанд асуудал үүсэх гээд байгаа Төсвийн тухай хуулиа өөрчилье, тодотгоё. Тэгэнгүүт хүрээний мэдэгдэлтэйгээ зөрөх гээд байгаа.

Тэр учраас Төсвийн тогтвортой байдлын хууль хөндөгдөх гэж байна. Аргагүй нөхцөл байдал үүслээ. Ирээдүйдээ төсвийн тэр орлого чинь доод хязгаартаа хүрэхгүй бол энэ хязгаараа авчихвал нөгөө төсвийн дүрмүүд чинь утгагүй болох гээд байна шүү дээ. Тэгвэл энэ хууль хэрэггүй, тэгвэл зөвлөл хэрэггүй болох гээд байна шүү дээ.

Тэгэхээр ядаж энэ жилдээ онцгой нөхцөл дандаа өөрчилж болохгүй байхгүй юу. Нөгөө орлого өөдрөг төсөвлөснөөс болоод дандаа тодотгочихдог гэдэг энэ байдал чинь үүрдийн, мөнхийн баталгаатай боллоо шүү дээ. Энэ бүх юмандаа уялдаа холбоотой ажиллалчиг гээд байгаа болохоос улс төр хийх сонирхол алга. Тэр оноо моноо авах сонирхолгүй ерөөсөө санаа зовж байна улс эх орондоо. Төсвийн сахилга батыг олон жил ярьсан хүний хувьд санаа зовоод хэлээд байгаа юм. Битгий хуумгай хандаач ээ. Яг чин сэтгэлээсээ, эдийн засгаа, төсөв санхүү, менежментээ бодоод ажиллаач гэж хүсэж байна шүү дээ. Тэрнээс хэн нэгэн улс төрчийг бариад л балбаад байвал амархан л байна шүү дээ. Энэ шинээр сонгогдсон сайд нарыг ойлгож байна. Өмнөх асуудлууд дээр гарч ирж байгаа биз дээ. Зөвхөн өмнөх 4 жил биш өмнөх 20, 30 жилийн асуудал хуримтлагдсан шүү дээ Монголд. Бүгд мэдэж байгаа. Одоо жоохон 126 болсон юм бол олигтой ажиллая гэж байна. За тийм байна.

**Ц.Даваасүрэн:** За дүрмээрээ тоглож гэж байна. Зөв зөв. Баясгалан гишүүн

**Ж.Баясгалан:** Энэ төсвийн төсөөллийн тухай хууль бүгдээрэн дээр нь л хэлж байгаа юм. Ерөөсөө дэндүү ингээд хийсвэр бодитой биш тиймээ, дэндүү тийм одоо мөрөөдлийн тийм төсөв оруулж ирээд байгаа юм. 2027 он, 2028 он, 2026 он ерөөсөө бүх төсөв дээрээ. Тэгээд одоо яг ингээд бодитой байдал дээрээ л бууж байна л даа. Тэгээд бодитой байдал дээрээ буугаад яг үнэхээр энэ 100 хувь бараг шахуу хараат болчихсон нүүрсний үнэ унаснаас болоод тэгээд энийг бол одоо унасан цагаас нь эхлээд л анхнаас нь хэлсэн шүү дээ. Энэ чинь уначхаад байна аа. Энэ жил уначхаад байхад энэ төсвөө үзээч ээ, бид нар ямар ч байсан энэ төсөөлөл болохлоор бид нар илүү их тийм одоо юутай нөгөө зорилттой байх ёстой гэж ярьдаг. Дэлхийн нүүрсний үнийг бид нар бол тогтоохгүй ээ. Тийм болохлоор энэ бол угаасаа бодитой байдалтайгаа эвлэрэх ёстой.

За тэгэхлээр үнэхээр яг бодитой байдалтайгаа эвлэрээд орж ирж байгаа энэ тохиолдолд бол одоо дэмжихээс өөр аргагүй. Дэмжинэ. Одоо дэмжиж байж л бид нар энэчээ орлогоо, зарлагаа бүгдийг нь тэнцүүлэхээс биш тэгээд дахиад л нөгөө хийсвэрээр худлаа төсөөлчихсөн төсөөлөл дээрээ зардлаа тооцож болохгүй. Дахиад л хэсэг хугацааны дараа одоо энэ чинь бүр болохоо байлаа гэсний дараа бүр дордсоны дараа дахиж сайжруулна гэж байхгүй. Тийм болохлоор бол энэ дээр би бол зарчмын хувьд бол дэмжээд явна аа. Дараа дараагийн удаа энэ хийсвэр, хэтэрхий мөрөөдлийн, хэтэрхий одоо тийм төсөөллөө одоо өөдрөгөөр хийдгээ л ерөөсөө болих хэрэгтэй. Энэ бол одоо хамгийн том сургамж болж байгаа шүү. За зарчмын хувьд бол дэмжиж байна аа.

**Ц.Даваасүрэн:** Пүрэвдаваа гишүүн байна уу, байгаа юу? За ингээд гишүүд бүгд байна уу? За би яах вэ санал хураахын өмнө та бүгдэд нэг юм танилцуулаад өгчихье. Энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийн 7.7-д болбол төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх хугацаанд хэрэгжих нөхцөл хугацааг нь өөрчлөгддөг юм байна уг нь. Төсвийн тусгай шаардлагыг. Төсвийн тусгай шаардлага болбол 4 нэгдсэн төсвийн орлогын тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх 1 дүгээр шаардлага, 2 дугаар шаардлага Нэгдсэн төсвийн суурь тэнцэл тухайн жилийн ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх. 3 дахь шаардлага бол нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх, 4 дэх шаардлага Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн ийм 4 шаардлага.

Тэгэхээр энэ 4 шаардлагад биш нөгөө төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт орвол 3 сараас доошгүй хугацаанд жилийн төсөв тодотголыг өргөн барьж болохгүй ээ гэсэн энэ заалттай л холбоотой юм. Гэхдээ яах вэ ер нь болбол бүгдээрээ бас нэг ирцээрээ хангалттай оролцоод ингээд саналаа хураачихсан нь дээр ээ. Тэгээд гишүүдэд баярлалаа.

25 гишүүнээс 23 гишүүн санал хураалтад оролцож байна аа. Санал хураалтдаа бэлтгэе гишүүд ээ. 23 гишүүн хуралдаанд оролцсон байна. Санал хураалт бэлэн болсон учраас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 23 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж, 78.3 хувиар энэ санал энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжлээ.

Тэгэхдээ ер нь яах вэ гишүүдийн хэлээд байгаа, болгоомжлоод байгаа зүйлийг бас бид нар бодох л ёстой л доо. Зүгээр төсвөө өргөн барьж чадахгүй болчихоод л гишүүд аргагүй хайчинд орчихоод л өнөөдөр энэ хуулийг дэмжиж байна шүү дээ. Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын хуулийн төсвийн сахилга батыг дэмжих юман дээрээ бид нар цаашдаа анхааралтай байх ёстой.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг нэгдсэн чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулах уу? За Мөнхсоёл танилцуулна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Эдгээр асуудлыг хэлэлцэж дууссан тул Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж, хуралдааныг хаасныг мэдэгдье ээ. Баярлалаа гишүүд ээ.

**10:55**

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ